

ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах жил

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН | 2022 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦЭС



АГУУЛГА	1
Товчилсон үгийн тайлбар	2-3
БҮЛЭГ 1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	4
1.1 Бүтэц, зохион байгуулалт	4
1.2 Аудитын үйл ажиллагаа	5
БҮЛЭГ 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	8
2.1. Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн	9
2.2. Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө	9
2.3 ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит	10
2.4. ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	10
БҮЛЭГ 3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	12
3.1 Гүйцэтгэлийн аудитын үр дүн	13
3.2 Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө	13
3.3 Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	15
3.4 Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	16
3.5 Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө	17
3.6 Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн	18
3.7 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг	19
3.8 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө	21
3.9 “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-д хийх гүйцэтгэлийн аудит	22
БҮЛЭГ 4. НИЙЦЛИЙН АУДИТ	24
4.1 Нийцлийн аудитын үр дүн	24
4.2 Нийцлийн аудитын үр нөлөө	25
4.3 “Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны орон нутгийн нөхөн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах”	25
4.4 “Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх”	25
4.5 “Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”	26
БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ	26
БҮЛЭГ 6. ДОТООД АЖИЛ	27
6.1 Сургалт	27
6.2 Хамтын ажиллагаа	28
6.3 Мэдээлэл сурталчилгаа	29
6.4 Албан харилцаа	30
6.5 Өргөдөл гомдол	32
6.6 Шагнал урамшуулал	32
6.7 Нууцын хадгалалт хамгаалалт	32
6.8 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	33
6.9 Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажлууд:	33
6.10 Мэдээллийн технологи	35
БҮЛЭГ 7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	35
БҮЛЭГ 8. ДҮГНЭЛТ	36
БҮЛЭГ 9. ШИНЭ САНААЧИЛГА	37
БҮЛЭГ 10. САНАЛ	39
ХАВСРАЛТ	
Товчилсон үгийн тайлбар	

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНГ	Аудитын нэгдүгээр газар
АХГ	Аудитын хоёрдугаар газар
АГГ	Аудитын гуравдугаар газар
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АТГ	Авлигатай тэмцэх газар
АРА	Архангай аймаг
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ББНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс
БШУ	Боловсрол шинжлэх ухаан
БӨА	Баян-Өлгий аймаг
ГСҮ	Говьсүмбэр
ДАДТАГ	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТА	Тэргүүлэх аудитор
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТГ	Тамгын газар
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
УВА	Увс аймаг
УИХ	Улсын Их Хурал
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НАА	Нийтийн аж ахуй
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХШУДАГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
ХХАГ	Харилцаа хамтын ажиллагааны газар
ХБТГ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар
МТТ	Мэдээллийн технологийн төв
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МТ	Мэдээллийн технологи

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар

ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗУГ	Захиргаа удирдлагын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗХЭЗГ	Захиргаа хууль эрх зүйн газар
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль

1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь 2022 онд ТАБ-ын хэмжээнд дэвшүүлсэн “Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах жил” зорилтын хүрээнд газрын 2022 онд хэрэгжүүлэх 3 бүлэг 33 арга хэмжээний гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчоор батлуулан ажиллалаа.


Төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн боловсрууллаа.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан аудит бүрд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан “Аудитын чанарын хяналтын журам”-ын дагуу аудитын үе шат бүрд чанарын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан. Мөн Монгол Улсын Ерөнхий аудитор зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг 2022 оны А/35 дугаар тушаалаар баталсныг үндэслэн дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны А/11 дүгээр тушаал гарган 3 арга хэмжээг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Тухайлбал Дорноговь аймагтай хамтран түншийн үнэлгээ хийсэн нь аудиторуудад үр өгөөжөө өгсөн ажил байлаа.

1.1 Бүтэц, зохион байгуулалт


Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/126 дугаар тушаалаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн “Зохион байгуулалтын бүтэц батлах тухай” дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны А/02 дугаар тушаалаар үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон дэмжих үйлчилгээний нэгжийн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Схем №1. “Газрын бүтэц, зохион байгуулалт”




Хүний нөөц


Ажилласан жилээр:




Насны бүтцээр:



Мэргэжил, мэргэшил:



Боловсролын зэрэг:



Төрийн аудитын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр тайлант онд аудитор М.Ухаанбилэгийг МУИС-д эрх зүйч мэргэжлээр суралцаж хос мэргэжил эзэмшихийг дэмжиж эчнээ сургалтын хөтөлбөрийн үед ээлжийн амралт болон цахимаар ажиллах гэрээ байгуулж 2 сарын цалинг олгосон. Мөн аудитор Б.Одхүү нь МУИС-ийн Дорнод аймаг дахь сургуульд Бизнесийн ухааны магистраар суралцаж байна. Ар гэрийн гачигдал, хүндэтгэн үзэх шалтгаанаар ахлах аудитор Б.Батжаргалд 2 хоногийн цалинтай чөлөө, аудитын менежер И.Сэмжидмаад ажлын 10 хоногийн цалинтай чөлөө, хагас сарын цалинтай тэнцэх тэтгэмж, ахлах аудитор Д.Нармандахад ажлын 5 хоногийн цалинтай чөлөө, аудитор Б.Одхүүд түлээ нүүрсний хөнгөлөлтийг тус тус олгохын зэрэгцээ ахлах аудитор Д.Нармандахад нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллалаа. Ахмад ажилтан Б.Дэлгэрмааг хүндэт дэвтэрт бичиж, журамд заасан урамшууллыг шийдвэрлэж, ахмадын баяраар Төрийн хяналт-Аудитын 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан ахмадуудаа хүлээн авч 3 үеийн уулзалтыг зохион байгуулж ажилласан. Мөн эрх зүйч аудитор М.Ганбилэгт зөөврийн компьютер, бичиг хэрэг хариуцсан аудитор С.Энхбаатарт камер, нийт албан хаагчдыг чихэвчээр хангасан.

1.2 Аудитын үйл ажиллагаа

Төрийн аудитын газар нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 199 аудитыг гүйцэтгэж, үүнээс Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх шатны төсөв захирагчдын төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд 189 бие даасан дүгнэлт гаргасан байна. Харин гүйцэтгэлийн 7 аудитад 83, нийцлийн 3 аудитад 18 байгууллага, нэгжийн үйл ажиллагааг тус тус хамруулсан байна. (Дүрслэл 1)

Дүрслэл 1. Гүйцэтгэсэн аудит /тоо/



Дүрслэл 2. Аудитын илрүүлэлт /сая.төг/



Гүйцэтгэсэн аудитын дүнгээр нийт 62,114.5 сая төгрөгийн 639 алдаа, зөрчил илрүүлж, тэдгээрийн 4.7 хувь буюу 2,920.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, нийт 151.9

сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 40,869.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 17,865.7 сая төгрөгийн зөрчилд 211 зөвлөмж, 105.1 сая төгрөгийн 14 хариуцлага тооцуулах албан шаардлага, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 3 ширхэг 201.5 сая төгрөгийн зөрчлийг Прокурорын байгууллагад шилжүүлэхээр Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлж, 2 асуудал нь аймгийн Прокурорын газар болон АТГ-д шалгагдаж байна. Харин 1 асуудал Монгол Улсын Ерөнхий аудиторын хяналтын түвшин байна.

Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын 5 жилээр харьцуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтийг харууллаа.

Дүрслэл 3. “Гүйцэтгэсэн аудитад хамрагдсан байгууллагууд (тоон харьцуулалт)



Төрийн аудитын газар нь 2022 оны жилийн эцсийн байдлаар улс, орон нутгийн төсөвт 48.8 сая төгрөгийг буюу гүйцэтгэлийн аудитын өмнөх оны төлбөрийн актын үлдэгдлээс 2.0 сая төгрөгийг, тайлант онд нийцлийн аудитаар 1.5 сая төгрөг, гүйцэтгэлийн аудитаар 2.4 сая төгрөг, санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актаас 42.9 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлж ажиллалаа. 2022 оны жилийн эцсийн байдлаар 28,613.2 сая төгрөгийн 107 санхүүгийн, 15 санхүүгийн бус үр өгөөжийг аудитад хамрагдсан байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөг тутамд 65.6 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

Дүрслэл 4. Аудитын үр нөлөө




Төлбөрийн акт: Тайлант хугацаанд 151.9 сая төгрөгийн 53 төлбөрийн акт тогтоосон байна. Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актаас 53.5 сая төгрөгийн 47, гүйцэтгэлийн аудитын өмнөх оны үлдэгдлээс 2.0 сая төгрөгийн 1, тайлант оны 2.4 сая төгрөгийн 2, нийцлийн аудитын 1.5 сая төгрөгийн 1 нийт 59.4 сая төгрөгийн 51 төлбөрийн

актыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээ. Тайлант онд тогтоосон 94.5 сая төгрөгийн 3 төлбөрийн актыг барагдуулах хугацаа болоогүй байна.


Албан шаардлага: Тайлант хугацаанд 40,869.4 сая төгрөгийн 278 албан шаардлага хүргүүлсэн байна. Жилийн эцсийн байдлаар тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 10,807.7 сая төгрөгийн 252 албан шаардлага, гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн 28,847.1 сая төгрөгийн 14 албан шаардлага, нийцлийн аудитын өмнөх оны албан шаардлагын үлдэгдэл 377.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хэрэгжсэн байна. Гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн 1,214.6 сая төгрөгийн 12 албан шаардлагын хугацаа болоогүй байна. Санхүүгийн тайлангийн аудитаар албан тушаалтанд хариуцлага тооцуулах 105.1 сая төгрөгийн 14 албан шаардлага хүргүүлсний 105.1 сая төгрөгийн 11 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, 3 албан шаардлагын хэрэгжээгүй байна.

Зөвлөмж: Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар 5,721.8 сая төгрөгийн 141, гүйцэтгэлийн аудитаар 12,143.9 сая төгрөгийн 70 нийт 17,865.7 сая төгрөгийн 211 зөвлөмж өгч ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,721.8 сая төгрөгийн 141 зөвлөмж бүрэн хэрэгжиж, гүйцэтгэлийн аудитын өмнөх оны үлдэгдлээс 22 зөвлөмж, нийцлийн аудитын өмнөх оны үлдэгдлээс 337.4 сая төгрөгийн 4 зөвлөмж, тайлант оны гүйцэтгэлийн аудитын зөвлөмжөөс 17.2 сая төгрөгийн 11 нийт 178 зөвлөмж хэрэгжсэн байна. Зөвлөмжийн үлдэгдэл 12,126.7 сая төгрөгийн 59 зөвлөмж байна. Энэ нь тайлант оны 3, 4 дүгээр улиралд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжүүд байна. Эдгээр зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.


Дүрслэл 5. Төлбөрийн акт (сая төгрөг)



Дүрслэл 6. Албан шаардлага (сая төгрөг)



Дүрслэл 7. Зөвлөмж (Тоо)




2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсөв захирагчид нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн СТОУС, НББОУС-д нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэхэд АДБОУС-д нийцүүлэн батлуулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-4:2020 “Санхүүгийн аудитын тулгуур зарчим”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан ТАБ-ын “санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”, 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”, 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан ТАБ-аас “2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”, “Төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж”-ийн хүрээнд Төсвийн хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангийн аудит хийж 78.6 сая төгрөгийн өртөг, 2670 хүн/өдөр зарцууллаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Хамрагдсан байгууллага 227



Аудитын санал дүгнэлт 189



Аудитын илрүүлэлт – 19,609.0




53.5 сая/төг
Акт



10,807.7 сая/төг
Албан шаардлага



5,721.8 сая/төг
Зөвлөмж



Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны жилийн эцсийн статистик мэдээ

2.1. Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн

Тайланг онд хуулиар тогтоосон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит этгээд, төсөл хөтөлбөрийн 227 санхүүгийн тайланд аудитыг гүцэтгэхдээ 189 байгууллагад бие даан дүгнэлт гаргаж, 38 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 189 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 184 буюу 97.4 хувьд зөрчилгүй, 4 буюу 2.1 хувьд хязгаарлалттай, 1 буюу 0.5 хувьд дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,609.0 сая төгрөгийн 534 алдаа зөрчил илрүүлснээс 2,920.9 сая төгрөгийн 80 алдааг санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулсан. Аудитаар залруулагдаагүй 53.5 сая төгрөгийн 47 зөрчилд төлбөрийн акт, 10,807.7 сая төгрөгийн 252

зөрчил арилгах албан шаардлага, 105.1 сая төгрөгийн 14 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн бол 5,721.8 сая төгрөгийн 141 зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар тогтоосон 53.5 сая төгрөгийн 47 төлбөрийн акт буюу 100 хувийг төсөвт төвлөрүүлэн, 10,807.7 сая төгрөгийн 252 албан шаардлага 100 хувь, 105.1 сая төгрөгийн 14 хариуцлага тооцуулах албан шаардлагын 78.6 хувь, 5,721.8 сая төгрөгийн 141 зөвлөмжийн биелэлтийг 100 хувь хангуулан ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхий аудиторт 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 418 тоот албан бичгээр өмнөх оны үлдэгдэл 11.8 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй Зэвсэгт хүчний 327, 329, 085 дугаар ангиудын захирагч нарт сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг уламжлаад байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 699.4 сая төгрөгийн 87 санхүүгийн үр өгөөжийг шалгадагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж бүртгэсэн.

Санхүүгийн тайлангийн завсрын аудитын төлөвлөгөөг 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр баталж, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн ажиллаж байна. Төсөвт байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 60 хуулийн этгээдэд санхүүгийн тайлангийн завсрын аудит хийхээр төлөвлөгөөнд тусгаж, үүнээс 25 хуулийн этгээдэд санхүүгийн тайлангийн завсрын аудит 41.7 хувийн гүйцэтгэлтэй хийж, шинэчилсэн www.fas.audit.mn цахим системд оруулаад байна.

Бид аудитыг хуульд заасан хугацаанд нэгдсэн арга зүйгээр чанартай гүйцэтгэхийн тулд үе шатны ажлуудад хугацааг оновчтой хуваарилах, аудитуудын ажлын гүйцэтгэлийг FAS.audit.mn цахим системд төлөвлөгөөний дагуу оруулан, хянаж баталгаажуулахад анхаарч ажиллаж байна.

2.2. Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө

Санхүүгийн тайлангийн аудитыг орон нутаг дахь бүх шатны төсөв захирагчид, санхүүгийн ажилтнуудыг оролцуулан хийж, аудит хийх багийн бүрэлдэхүүн, аудитаар баримтлах бодлого, чиглэл, үүрэг хариуцлагыг жил бүр танилцуулж, аудитын нээлтийг хийж хэвшсэн нь шалгадагч байгууллагуудын аудитын үйл ажиллагаанд оролцох хариуцлага, хандлага төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналт сайжирч, материаллаг шинж чанартай алдаа зөрчил жил бүр буурч байна.

Мөн ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу "Ашдын нөхөр" ХХК-ний аймгийн бүх сумдад цацагддаг "Дорнод" телевизтэй гэрээ байгуулан санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгийн талаар ил тод нээлттэй ярилцлага өгч иргэд, олон нийтэд мэдээллийг цаг хугацаанд нь хүргэж байна.


2.3 ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТЕЗ-ийн хамрах хүрээний 185 байгууллага хамрагдахаас 38 байгууллага түүвэрт хамруулан, 147 байгууллагад санал дүгнэлт өгч ажиллалаа. Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан аргачилсан зөвлөмжид хэрэгжүүлэхээр заагдсан нийт 6 ерөнхий чиглэлд горим, сорил хэрэгжүүлж, үр дүнг аудитын тайланд тусгаж ажиллалаа. "Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл" болон "Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж"-ийг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажилласан.



ОНТЕЗ нийт алдаа зөрчил
18,367.2 сая төгрөг

Аудитаар нийт 18,367.2 сая төгрөгийн 424 алдаа, зөрчил илрүүлснээс 2,234.7 сая төгрөгийн 68 алдааг залруулж, 28.5 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 10,823.4 сая төгрөгийн зөрчилд 226 албан шаардлага, 5,280.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 99 зөвлөмж өгсөн.



Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах 43 байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод 6063 мэдээ байршуулахаас 13,508.5 сая төгрөгийн 705 мэдээллийг байршуулаагүй, 395.7 сая төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Иймд 3 байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал, 48 байгууллагад зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж, 26 байгууллагад зөвлөмж өгч ажиллалаа.


Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант онд нийт 156 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 32 мэдээллийг хугацаа хоцроон, 10 мэдээллийг байршуулаагүй байна. Өмнөх аудитаар өгсөн зөрчлийг давтан гаргасанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг өгч ажилласан.

ТЕЗ-ын нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч аудитын тайлан дүгнэлтийг аймгийн Засаг дарга болон УАГ-ын АХГ-т хүргүүлсэн.

2.4. ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан нийт орлого ба тусламжийн 84,665.7 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн 79,953.5 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулж дүгнэлт гаргалаа.

Аудитаар нийт 1 зөвлөмж өгч, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах 4 саналыг УАГ-т уламжлан аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторов А/07 дугаартай тушаалаар баталгаажуулж, аймгийн ИТХ, Засаг дарга болон АХГ-т хүргүүлсэн.



Дорнод аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 84.4 хувийн гүйцэтгэлтэй байгаад сумдын төвлөрүүлэн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүд нөлөөлж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/111 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмжийн дагуу ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг нийцлийн аудиттай хослуулан хийсэн.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn болон open.audit.mn сайтад тус

тус байршуулж ажиллалаа.

3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газар нь шалгагдаж буй байгууллагыг чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг арвигч хямгач, үр ашигтай, үр нөлөөтэй ашиглаж байгаа эсэхэд АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6827-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”, “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам” гарын авлагын хүрээнд аудит хийж, давхардсан тоогоор 159.5 сая төгрөгийн өртөг, 1003 хүн/өдөр зарцууллаа.


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



7
Аудит
гүйцэтгэсэн



83
Байгууллагыг
хамруулсан



Эхний үлдэгдэл	Тайланг онд тогтоосон	Хэрэгжсэн	Үлдэгдэл
Сая төгрөгөөр			
1 - 2.0	5 - 96.9	3 - 4.4	3 - 94.5
Акт			
0	26 - 30,061.7	14 - 28,847.1	12 - 1,214.6
Албан шаардлага			
22 - 0	70 - 12,143.9	33 - 17.2	59 - 12,126.7
Зөвлөмж			
0	3 - 201.5	3 - 201.5	
Хуулийн байгууллагад шилжүүлсэн			

Тайлбар: Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо - мөнгөн дүн /сая.төг/ гэсэн дарааллаар харна.

Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны жилийн эцсийн статистик мэдээ

3.1 Гүйцэтгэлийн аудитын үр дүн

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө”, “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд гүйцэтгэлийн аудит хийж арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад тулгуурлан тайлагнаж, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний хүрээнд 2022 онд 7 гүйцэтгэлийн аудитыг хийхээр төлөвлөснөөс 7 аудитад 83 байгууллагыг хамруулан аудитыг 100.0 хувь хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэлээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 42.5 тэрбум төгрөгийн 104 зөрчил илрүүлж 96.9 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 30.1 тэрбум төгрөгийн зөрчилд 26 албан шаардлага, 12.1 тэрбум төгрөгийн зөрчилд 70 зөвлөмж, нэгтгэсэн тайланд тусгуулах 21 санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжлан хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх 201.5 сая төгрөгийн 3 саналыг өгч ажиллалаа.

Тайлант онд өгсөн 70 зөвлөмжийн 11 нь хэрэгжиж, 3,4 дүгээр улиралд гүйцэтгэсэн аудитуудын 59 зөвлөмжийн хугацаа болоогүй байна.

Өмнөх оны үлдэгдэл 2.0 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, тайлант онд тавигдсан 96.9 сая төгрөгийн 5 төлбөрийн актаас 2.4 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг барагдуулж, 94.5 сая төгрөгийн 3 төлбөрийн актын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Тайлант онд бичигдсэн 30.1 тэрбум төгрөгийн 26 албан шаардлагаас 28.8 тэрбум төгрөгийн 14 албан шаардлага хэрэгжиж, 1.2 тэрбум төгрөгийн 12 албан шаардлагын биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”, “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд хийсэн аудитуудаар гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудал илэрсэн тул ТАТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасны дагуу МҮЕА-т уламжилж, 2 асуудалд Прокурорын газар, Авлигатай тэмцэх газарт ажиллагаа явагдаж байна. Харин 1 асуудал Монгол Улсын Ерөнхий аудиторын шийдвэрлэх шатанд байна.

3.2 Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар болон газрын бодлого, шийдвэрийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө”, “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд гүйцэтгэлийн аудит хийж арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад түшиглэн тайлагнаж, дүгнэлт, зөвлөмж, саналыг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Улсын хэмжээнд нэгдсэн төлөвлөгөөгөөр жил бүр давтан хийгдэж байгаа улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийж буй аудитын үр дүнд алдаа

зөрчлийн төрөл буурч, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт сайжирч байна.

Аудитуудын хүрээнд аймгийн төвийн болон 13 сумдын хөрөнгө оруулалтын ажлыг объект дээр нь биет горим, сорил хэрэгжүүлж, ашиглагч тал, иргэд олон нийтийн сэтгэл ханамжийг үнэлж, санал асуулгын дүнг аудитад ашиглалаа.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн санд хийсэн аудитаар төлөвлөлтийг тооцоо судалгаа, ТЕЗ-ийн саналд үндэслэхгүй, ТАХ-ний эрхийг хуулийн хугацаанаас хоцроож шилжүүлж, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалан зарим ТАХ-нүүд цаашид хэрэгжихгүй болсон, зорилтот үр дүнгийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байгаа тухай дүгнэлтийг гаргасан.

Нэгдсэн удирдамжаар “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар хөтөлбөрүүдийн санхүүжилт оновчгүй, мэдээллийн үнэн зөв бодитой байдал хангалтгүй, нийтлэг үйлчилгээ, нийтийг хамрах ажлын зардлын зарцуулалт хангалтгүй, хяналт-шинжилгээ үнэлгээ хангалтгүй байгаа нь төрөөс хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт хангалтгүй, үр нөлөөгөө өгөхгүй байгаа талаар дүгнэлтүүдийг өгсөн.

Нэгдсэн удирдамжаар “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хөгжүүлэх бодлого байхгүй, төрийн өмчит хувьцаат компани нь үйл ажиллагааны зардлыг арвилан хэмнэлтгүй, оновчгүй төлөвлөж, зарцуулж байгаа талаар дүгнэлтүүдийг өгсөн.


Нэгтгэн тайлагнах аудитын хүрээнд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд хийсэн аудитаар ЖДҮ-г хөгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, төсөл сонгон шалгаруулах үйл явц удаашралтай, эрэмбэлэх үйл явц учир дутагдалтай, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, ажлын байрыг төлөвлөсөн хэмжээнд нэмэгдүүлээгүй, зарим зээлийг зориулалт бусаар зарцуулсан талаар аудитын дүнд тусгалаа.

Нэгтгэн тайлагнах аудитын хүрээнд “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд хийсэн аудитаар халамжийг хавтгайруулан олгож, зорилтод эмзэг бүлэгт чиглүүлээгүй, халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхцалыг тооцон үздэггүй, нийгмийн халамжийн үйлчилгээнд дундаж болон дунджаас дээгүүр амьдралтай өрх-иргэн хамрагдах боломжтой, хүнсний эрхийн бичигт хамрагддаг өрх-иргэдийн амьжиргааны түвшингийн мэдээллийг шинэчилж, хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй талаар дүгнэлтүүдийг өгсөн.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 27,912.3 сая төгрөгийн 19 санхүүгийн үр өгөөж, 15 санхүүгийн үр өгөөжийг бүртгэсэн.

3.3 Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Аудитын товч дүн



Нэгдсэн удирдамжийн хүрээнд “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийх аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2022 оны 02 дугаар сарын 28-наас 4 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитад 7.6 сая төгрөгийн өртөг, 3 хүн 44 өдөр зарцуулан, баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь биет горим хэрэгжүүлэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга, тайлбар авах, санал асуулгын дүн нэгтгэх, тоон болон чанарын мэдээлэлд харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн. Аудитаар нийт 3,350.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 384.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 6 саналыг YAГ-ын Аудитын 3-р газарт хүргүүлж ажилласан.



Аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар баталгаажуулж, YAГ болон аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, УЦУОШТ-ийн дарга нарт 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 472, 473, 474, 475 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж, инфографик хэлбэрээр бэлтгэн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар мэдээлсэн.

Аудитын явцад үүссэн нотлох баримт, дүн шинжилгээг үндэслэн улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна гэж дүгнэн 384.0 сая төгрөгийн 1 санхүүгийн, 2 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэлээ.

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2021 ОНД АШИГЛАЛТАД ХҮЛЭЭЖ АВСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



1 соёлын төвийн барилга /Баян-Уул сум/



1 цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Хэрлэн сум/



2 УЦУОШТ-ийн барилгын гадна болон дээврийн засвар /Хэрлэн, Баян-Уул сум/



1 цэцэрлэгийн шугам сүлжээний засвар /Хэрлэн сум/



1 сумын инженерийн шугам сүлжээ /Халхгол сум/

НИЙТ 3,827.2 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ

3.4 Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Аудитын товч дүн



1.0 тэрбум төгрөг
21 төсөл, арга хэмжээ



Төсөл, арга хэмжээний
гүйцэтгэл **98.8%**



2,359.1 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



6 зөвлөмж **237.1** сая төгрөг
3 санал **2,122.0** сая төгрөг

Нэгдсэн удирдамжийн хүрээнд “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийх аудитыг 2022 оны 02 дугаар сарын 28-аас 4 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт 2021 онд 1,029.7 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталж хэрэгжүүлсэн байна.

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хамрагдлаа.

Аудитад 7.6 сая төгрөгийн өртөг, 3 хүн, 44 өдөр зарцуулж, баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь очиж биет горим хэрэгжүүлэх, судалгаа хийх, ярилцлага, тайлбар тодруулга авах, санал асуулга авч нэгтгэн дүгнэх, тулган баталгаажуулалт хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 2,359.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 237.1 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, нэгдсэн тайланд тусгуулах 2,122.0 сая төгрөгийн 3 саналыг Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжилж ажиллалаа.

Аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/08 дугаар тушаалаар баталгаажуулсан.

Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг даргад 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 471, 473, 474 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж, инфографик хэлбэрээр бэлтгэн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар мэдээлсэн.

Аудитын явцад үүссэн нотлох баримт, дүн шинжилгээг үндэслэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна гэж дүгнэн 17.2 сая төгрөгийн 1 санхүүгийн, 3 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэлээ.


ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



2 барилгын дээврийн засвар /АЗДТГ, “Хан-Уул” цогцолбор сургууль/



2 цэцэрлэгийн барилгын гадна засвар /14-р цэцэрлэг, 3-р цэцэрлэг/



2 барилга, орон сууцны их засвар /"Үжин" төв, Бунхны 12 айлын орон сууц/



Чиглэлийн автозам, гүүрний засвар арчлалт /2-р багт сайжруулсан шороон зам, Төв замын



асфальт, Модон гүүрний арчлалт, Баян-Уул сумын Эрээн даваа, Зүүн бетон болон модон гүүрний автомат хаалт, Хэрлэн-Халхгол чиглэлийн замын тэмдэг, Хөлөнбуйр бетон гүүрний замын арчлалт/



3 хөшөө, дурсгал /Чойбалсангийн хөшөө, Манлайбаатарын хөшөө, Ахмад дайчдын хөшөө/



1 газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Орон нутгийн өмчийн газар/



8 газрын автомашин, түүний сэлбэг хэрэгсэл /Аймгийн ЗДТГ, ИТХ, ЭМГ, ОНӨГ, Халхгол, Баянтүмэн, Чойбалсан, Улаан загалмайн хороо/

НИЙТ 827.9 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээ

3.5 Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө

Аудитын товч дүн



11.1 тэрбум төгрөг
195 төсөл, арга хэмжээ



Төсөл, арга хэмжээний
гүйцэтгэл **70.7%**



2,222.0 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



6 албан шаардлага **1,005.4** сая төгрөг
7 зөвлөмж **1,216.6** сая төгрөг
нэгдсэн тайланд тусгах **2** санал

Нэгдсэн удирдамжийн хүрээнд "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн"-д хийх аудитыг 2022 оны 4 дүгээр сарын 18-наас 6 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт 2021 онд 15,431.1 сая төгрөгийн 276 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталснаас 11,096.2 сая төгрөгийн 195 төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумдын ИТХ, ЗДТГ-ууд хамрагдлаа.

Аудитад 4.9 сая төгрөгийн өртөг, 68 хүн/өдөр зарцуулж, баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь очиж биет горим хэрэгжүүлэх, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 2,222.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,005.4 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 1,216.6 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж, нэгдсэн тайланд тусгуулах 2 саналыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт уламжилж ажиллалаа.



Аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталгаажуулсан.

Аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 489, аймгийн ИТХ, Засаг даргад 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 490, 491 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулан 2023 оны 3 дугаар сарын 25-ны дотор тайлагнана.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж, инфографик хэлбэрээр бэлтгэн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар мэдээлсэн.

Аудитын явцад үүссэн нотлох баримт, дүн шинжилгээг үндэслэн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтот үр дүн 70.7 хувьтай байна гэж дүгнэн 1,440.6 сая төгрөгийн 2 санхүүгийн, 4 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэлээ.

3.6 Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

Аудитын товч дүн



20.5 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



1 акт 5.7 сая төгрөг
1 албан шаардлага 3.5 сая төгрөг
8 зөвлөмж, нэгдсэн тайланд тусгах
3 санал, хууль хяналтын байгууллагад
шилжүүлэх 11.2 сая төгрөгийн 1 санал

Нэгдсэн удирдамжийн хүрээнд “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийх аудитыг 2022 оны 3 дугаар сарын 02-ноос 5 дугаар сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд 2016-2021 онд 919.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын 2016-2021 оны нийт зарлагын 38.1 хувийг хөдөлмөр эрхлэлтийн зориулалтын зардал, 58.7 хувийг мэргэжлийн боловсролын зардал, 3.2 хувийг хөдөлмөр эрхлэлтийн хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

Статистикаас харахад Дорнод аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн тоо 2019-2020 онд хамгийн өндөр өсөлттэй, 2016-2018 онд тогтмол бууралттай байх бөгөөд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо тогтмол буурсан үзүүлэлттэй байна. Мөн ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 2016 онд 1.2, 2017 онд 1.3, 2019 онд 10.9, 2020 онд 7 хувиар тус тус өссөн дүнтэй байсан.

Аудитад аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Статистикийн хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл, Мэргэжлийн сургалт,



үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж, сумдын хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдийн 2016-2020 оны үйл ажиллагааг хамруулсан.

Аудитад 14.1 сая төгрөгийн өртөг, 5 хүн, 35 өдөр зарцуулж, аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх, газар дээр нь очиж биет горим хэрэгжүүлэх, албан тушаалтнуудаас ярилцлага, тодруулга, тайлбар авах, ажилгүй иргэдээс санал асуулга авч нэгтгэх, холбогдох хөтөлбөрийн санхүүжилтийн судалгаанд харьцуулсан дүн шинжилгээ, нэгтгэх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 20.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 5.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 3.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 8 зөвлөмж өгч, нэгдсэн тайланд тусгуулах 3 санал, 11.3 сая төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх саналыг ЯАГ-ын Аудитын 3-р газарт уламжилж ажиллалаа.

Аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар баталгаажуулсан.

Аудитын тайланг ЯАГ-ын Аудитын 3-р газар болон аймгийн ИТХ, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллежид 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 478, 479, 480, 481, 482, 483, 484 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж, инфографик хэлбэрээр бэлтгэн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар мэдээлсэн.

Аудитын явцад үүссэн нотлох баримт, дүн шинжилгээг үндэслэн төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүнгүй байна гэж дүгнэн 5,7 сая төгрөгийн 1 санхүүгийн, 5 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэлээ.

3.7 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг



39,232.0 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Төлбөрийн акт 2.4 сая төгрөг
Албан шаардлага 28,847.2 сая төгрөг
Зөвлөмж 10,250.5 сая төгрөг
Прокурорт шилжүүлсэн 131.8 сая төгрөг

Газрын дарга, тэргүүлэх аудиторов баталсан дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т хийх гүйцэтгэлийн аудитыг 2022 оны 4 дүгээр сарын 13-аас 7 дугаар сарын 08-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

ДБЭХС ТӨХК-ний нийт хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн засаглалыг хэрэгжүүлж ажилладаг байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор ДБЭХС ТӨХК-ний дүрмийг баталж, ТУЗ-ийн гишүүдийг томилж ажилласан байна. ДБЭХС ТӨХК-ийн ТУЗ нь 9 гишүүнтэй байна.

Дорнод нийтийн аж ахуй болон Чойбалсан хөгжил орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын хөрөнгийг 100 хувь орон нутаг эзэмшиж байна. Аймгийн ИТХ-аас Дорнод Нийтийн аж ахуй, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-уудын дүрмийг баталж, ТУЗ-ийн гишүүдийг томилж ажилласан байна. Дорнод НАА, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын ТУЗ нь 9 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Аудитад ДБЭХС ТӨХК, Дорнод нийтийн аж ахуй, Гэрэл сэтгэмж, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ нийт 4 байгууллага хамрагдлаа.

Аудитад 15.0 сая төгрөгийн өртөг, 159 хүн/өдөр зарцуулан, судалгаа, шинжилгээ хийх, ярилцлага хийх, тодруулга, тулган баталгаажуулалт хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 39,232.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 2,4 сая төгрөгийн 2 ширхэг төлбөрийн акт, зөрчил арилгуулах 28,847.2 сая төгрөгийн 14 албан шаардлага, 10,250.5 сая төгрөгийн 19 зөвлөмж өгч, 131.8 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн.

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т хийх гүйцэтгэлийн аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар баталгаажуулсан. Аудитын тайлан, судалгаа, зөрчлийн нэгтгэлийг УАГ-ын аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболдод 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 514 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Аудитын тайланг шалгадагч байгууллага болох ДБЭХС ТӨХК-д 523, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-т 522, Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-т 521 тоот албан бичгээр, мөн аймгийн Засаг даргад 520, ИТХ-д 519 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Аудитын явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэхээр Монгол Улсын Ерөнхий аудиторт 2022.07.27-ны өдрийн 517 тоот албан бичгээр уламжилсныг шийдвэрлэж АТГ-т хянагдаж байна.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж, инфографик хэлбэрээр бэлтгэн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар мэдээлсэн.

Аудитын явцад үүссэн нотлох баримт, дүн шинжилгээг үндэслэн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хөгжүүлэх бодлого байхгүй, төрийн өмчит хувьцаат компани нь үйл ажиллагааны зардлыг арвиалан хэмнэлтгүй, оновчгүй төлөвлөж, зарцуулж байна гэж дүгнэн 25.8 тэрбум төгрөгийн 10 санхүүгийн үр өгөөжийг бүртгэлээ.

3.8 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө

Аудитын товч дүн



204.3 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



2 төлбөрийн акт **88.8** сая төгрөг
1 албан шаардлага **60.0** сая төгрөг
19 зөвлөмж, нэгдсэн тайланд тусгах
3 санал

Нэгдсэн удирдамжийн хүрээнд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд хийх аудитыг 2022 оны 8 дугаар сарын 08-наас 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

ХХААХҮС-ын 2019 оны А-41, 2020 оны А-131 дүгээр тушаалаар Дорнод аймагт 2019-2020 онд ЖДҮХС-аас нийт 2.0 тэрбум төгрөгийн зээл олгох эрхийг баталсан байна. ЖДҮХС-аас 2019 онд Дорнод аймагт 12 аж ахуйн нэгж, иргэнд 825.0 сая төгрөг, 2020 онд Дорнод аймагт 8 аж ахуйн нэгжид 422.1 сая төгрөг нийт 1,247.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгосон байна.

Аудитад ЖДҮХС-ийн 2019-2020 оны үйл ажиллагаа, аймгийн төсвөөс 2019-2020 онд олгосон ЖДҮ-ийн үйл ажиллагаа мөн аймгийн ЗДТГ, ХХААГ, ЖДҮ-г дэмжих төв, Хаан банкны Дорнод салбар, Хас банкны Дорнод салбар, ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг хамруулж авч үзлээ.

ЖДҮ-г хөгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, төсөл сонгон шалгаруулах үйл явц удаашралтай, эрэмбэлэх үйл явц учир дутагдалтай, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, ажлын байрыг төлөвлөсөн хэмжээнд нэмэгдүүлээгүй, зарим зээлийг зориулалт бусаар зарцуулсан талаар аудитын дүнд тусгалаа.

Аудитын хүрээнд нийт 17.9 сая төгрөгийн өртөг, 4 хүн, 65 өдөр зарцуулж, аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх, газар дээр нь очиж биет горим хэрэгжүүлэх, албан тушаалтнуудаас ярилцлага, тодруулга, тайлбар авах, төсөл хэрэгжүүлэгч иргэдээс санал асуулга авч нэгтгэх, холбогдох төсөл, арга хэмжээний судалгаанд харьцуулсан дүн шинжилгээ хийж, нэгтгэх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 204.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 88.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 60.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 55.5 сая төгрөгийн 19 зөвлөмж өгч, холбогдох байгууллагад уламжлах 3 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлж ажиллав.

Аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар баталгаажуулсан.

Аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, ЖДҮ-г дэмжих төв болон Хас банкны Дорнод салбарт 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 572-576 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Дорнод, Говьсүмбэр аймгуудын “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын нэгтгэсэн тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбатад 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 557 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж, инфографик хэлбэрээр бэлтгэн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар мэдээлсэн.

Аудитын явцад үүссэн нотлох баримт, дүн шинжилгээг үндэслэн ЖДҮХС-гийн 2019, 2020 оны үйл ажиллагаа Дорнод аймагт үр нөлөөгөө өгөөгүй байна гэж дүгнэн 144,3 сая төгрөгийн 3 санхүүгийн үр өгөөжийг бүртгэлээ.



3.9 “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-д хийх гүйцэтгэлийн аудит



204.2 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага **145.7** сая төгрөг
Зөвлөмж **7** ширхэг
Прокурорт шилжүүлсэн **58.5** сая төгрөг

Газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд хийх гүйцэтгэлийн аудитыг 2022 оны 7 дугаар сарын 02-оос 11 дүгээр сарын 15-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 “**нийгмийн халамж**” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг; заасан. гэтэл хүн амын өсөлтийг дэмжсэн хүүхдийн мөнгө, цалинтай ээж хөтөлбөр, эхийн алдар одонгийн мөнгө, насны хишиг, ахмадын амралтын хөнгөлөлт зэрэг хуульд заасан нийгмийн халамж гэсэн тодорхойлолттой нийцэхгүй үйлчилгээнүүдийг халамжийн сангаас олгож байна.

Аудитад аймаг, сумдын ЗДТГ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нийт 16 байгууллага хамрагдлаа.

Аудитад 30.0 сая төгрөгийн өртөг, 330 хүн/өдөр зарцуулан, судалгаа, шинжилгээ хийх, ярилцлага хийх, тодруулга, тулган баталгаажуулалт хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 204.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 145.7 сая төгрөгийн 4 албан шаардлага, 7 зөвлөмж өгч, 58.5 сая төгрөгийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээтэй холбоотой гарсан асуудлыг Прокурорын байгууллагад шилжүүлэх саналыг Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжилж, нэгдсэн тайланд оруулах 5 саналыг боловсруулж ажиллалаа.

“Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд хийх гүйцэтгэлийн аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/25 дугаар тушаалаар баталгаажуулсан.

Аудитын тайланг шалгадагч байгууллага болох Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2022.11.15-ны өдрийн 571 тоот албан бичгээр, аймгийн Засаг даргад мөн өдрийн 570, ИТХ-д 569 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Архангай, Баян-Өлгий, Дорнод, Увс аймгуудын “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын нэгтгэсэн тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбатад 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 557 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Аудитын явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэхээр МУЕАТ-т 2022.11.18 өдрийн 561 тоот албан бичгээр уламжилсан.



Мөн иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор аудитын тайланг audit.mn сайтад байршуулж, инфографик хэлбэрээр бэлтгэн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар мэдээлсэн.

Аудитын явцад үүссэн нотлох баримт, дүн шинжилгээг үндэслэн зорилтод эмзэг бүлгийн иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна гэж дүгнэн 70,9 сая төгрөгийн 1 санхүүгийн үр өгөөжийг бүртгэлээ.

4. НИЙЦЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газар нь шалгадагч байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудит” стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам” гарын авлагын хүрээнд аудит хийж, давхардсан тоогоор 5.1 сая төгрөгийн өртөг, 57 хүн/өдөр зарцууллаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



3
Аудит
гүйцэтгэсэн



18
Байгууллагыг
хамруулсан

Эхний үлдэгдэл	Тайланг онд тогтоосон	Хэрэгжсэн	Хуулийн байгууллагад шилжсэн
4 - 5,368.2	1 - 1.5	Сая төгрөгөөр Акт	1-1.5 4 - 5,368.2
2 - 377.0		Албан шаардлага	2 - 377.0
4 - 337.4		Зөвлөмж	4 - 337.4

Тайлбар: Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо - мөнгөн дүн /сая.төг/ гэсэн дарааллаар харна.

Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны жилийн эцсийн статистик мэдээ

4.1 Нийцлийн аудитын үр дүн

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны орон нутгийн нөхөн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах”, “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх”, “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д нийцлийн аудит хийж хууль тогтоомж, захиргааны хэм

хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд дүгнэлт, зөвлөмж гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний хүрээнд 2022 онд 3 нийцлийн аудитыг хийхээр төлөвлөснөөс 3 аудитад 18 байгууллагыг хамруулан аудитыг 100.0 хувь хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.

Тайлант онд нийцлийн аудитаар 1.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоосон. Өмнөх оны үлдэгдэл 5,368.2 сая төгрөгийн 4 төлбөрийн акт хууль, хяналтын байгууллагад шилжсэн.

Өмнөх оны үлдэгдэл 337.4 сая төгрөгийн 4 зөвлөмж, 377.0 сая төгрөгийн 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

4.2 Нийцлийн аудитын үр нөлөө

Орон нутгийн ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах аудитын үр дүнд улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн.

Орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аудитын үр дүнд орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоож холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, иргэд олон нийтэд мэдээлсэн.


Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулах, дүгнэлт гаргах аудитын үр дүнд улс төрийн намуудын хандивын тайланг ТАБ-ын цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд мэдээлсэн.

Нийцлийн аудитаар 1.5 сая төгрөгийн 1 санхүүгийн үр өгөөжийг бүртгэсэн.

4.3 “Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны орон нутгийн нөхөн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах”

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасны дагуу 2022 оны орон нутгийн нөхөн сонгуульд оролцож, сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын Ардчилсан нам, Монгол ардын намын мөрийн хөтөлбөр, хандивын тайланд гаргасан дүгнэлтийг www.audit.mn цахим сайтад 2022 оны 5 дугаар сарын 29-ний өдөр байршуулсан.

4.4 “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох бие даагч, нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх”



Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх” нотлох аудитыг төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн газрын дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны А/20 дугаар тушаалаар батлан аймгийн Сонгуулийн хороонд 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 532 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан.

Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцсон 2 намын 7 нэр дэвшигчийн зардлын дансанд орлого, зардлын гүйлгээ хийгдээгүй, мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй талаар хугацаанд нь нийтэд мэдээлсэн.

4.5 “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”



“Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д аудитыг төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн газрын дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны А/15 дугаар тушаалаар батлан аймгийн Сонгуулийн хороонд 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 515 дугаар албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд 22.9 сая төгрөг, 3 сумын хэсгийн хороодод 22.6 сая төгрөг, нийт 45.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Аудитаар 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон төсөвт бүрэн төвлөрүүлэн ажилласан.

5. ОРОН НУТГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасны дагуу Дорнод аймгийн 2023 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.



Аудитаар 8.5 сая төгрөгийн өртөг, 72 хүн/өдөр зарцуулж, АДБОУС -д нийцүүлэн батлуулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-4:2020 “Санхүүгийн аудитын тулгуур зарчим”, MNS6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” стандарт, МҮЕА-ын баталсан 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/59 тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуульд тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/67 тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-д заасанчлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга

зүйг ашиглаж, хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажилласан.

Дорнод аймгийн орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд 720.1 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх, 3,348.4 сая төгрөгийн зарлагыг бууруулах, 2,286.6 сая төгрөгийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт бүхий тайланг өгч 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 565 дугаар албан бичгээр аймгийн ИТХ-ын даргад, 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дарга, тэргүүлэх аудиторов А/27 дугаар тушаалаар баталгаажуулан 2022 оны 12 сарын 05 өдрийн 580 дугаар албан бичгээр аймгийн Засаг даргад тус тус хүргүүлж ажиллалаа. Аудитаар өгсөн санал дүгнэлтээр танилцуулга бэлтгэн 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн аймгийн ИТХ-аар 13 дугаар хуралдаанд танилцуулсан..



Батлагдсан төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд төсвийн орлогыг 720.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зардлыг 100.0 сая төгрөгөөр бууруулж, төсвийн үр ашгийг 2,286.6 сая төгрөгөөр сайжруулан баталсан байна. Энэ нь төсвийн орлого нэмэгдүүлэх санал 100 хувь, зардал бууруулах санал 3.0 хувь, төсвийн үр ашгийг сайжруулах санал 100 хувь хэрэгжсэн байна.


Шүүх, Прокурорт шилжсэн төлбөрийн акт:

Тайлант оны эхний үлдэгдэл 5,368.2 сая төгрөгийн 4 төлбөрийн актыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Үүний 5,315.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт нь Хэнтий аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа “Петроцайна дачин тамсаг” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Дорнод аймгийн Төрийн аудитын газарт холбогдох “Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын нэр бүхий аудитор нарын үйлдсэн ДОА-2020/06-НА 03/80 тоот Төлбөрийн актыг илт хууль бус болохыг тогтоолгох” шаардлага бүхий нэхэмжлэлтэй захиргааны хэргийн шүүх хурлын товыг тогтоох урьдчилсан хэлэлцүүлэг болж шүүх хурал 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 15 цагт болсон.

Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн аудитаар ТООУ ХХК-д тавьсан 21,556.0 мянган төгрөгийн төлбөрийн акттай холбоотой шүүх хурал болж шүүхийн №138/ШШ2021/00345 тоот шийдвэрээр 5,884.0 мянган төгрөгийг төлүүлэх, 15,672.0 мянган төгрөгийг хэрэгсэхгүй болгосон байна.

6. ДОТООД АЖИЛ

6.1 Сургалт



Дотоод сургалт

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх” зорилт, Төрийн аудитын байгууллагын 2022 оны “Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах жил” болгон тодорхойлсонтой холбогдуулан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор газрын 2022 онд хэрэгжүүлэх сургалтын сэдвүүдийг боловсруулан нийт 6 төрлийн сургалт зохион байгуулахаар дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны А/04 дүгээр тушаалаар баталсан. Сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 6 сургалтыг 100% амжилттай зохион байгуулсан. (Хавсралт 1)

ҮАГ-аас хийсэн сургалт

ТАГ-ын албан хаагчид 2022 оны 4-р улирлын байдлаар аудитын арга зүйтэй холбоотой-8, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой-4, хууль эрх зүйтэй холбоотой-5, цахим системийг ашиглахтай холбоотой-5, хувь хүний хөгжилтэй холбоотой-13, аудиторуудыг чадавхжуулахтай холбоотой-6, мэргэжлийн тасралтгүй сургалт-5, Тэргүүлэх аудиторов хамрагдсан болон үйл ажиллагаатай холбоотой-5, бусад-2, нийт 56 сургалтад хамрагдсан. (Хавсралт 2)

Бусад сургалт

Дорнод аймаг дахь Төрийн аудитын албан хаагчид өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль, Дорнод аймаг дахь Их сургууль, Төрийн албаны зөвлөл, ММНБИ, Оюун ухааны академийн сургалтад хамрагдсан. (Хавсралт 3)

6.2 Хамтын ажиллагаа



Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлж, бодит үр дүн нэмэгдүүлэхээр дараах ажлуудыг зохион байгууллаа.

Харилцагч талуудын оролцооны 5 бүлэг 9 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж уг төлөвлөгөөний биелэлтийг Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн

газрын Судалгаа, шинжилгээ хариуцсан шинжээч Ж.Дэмчигсүрэнд цахимаар хүргүүлэн ажилласан.

Тайлант оны эхэнд аудитыг гүйцэтгэх баг бүрэлдэхүүн, гэрээгээр санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх хувийн аудитын компани болон төсвийн захирагчид, санхүүгийн ажилтнуудыг оролцуулан аудитыг нээж, тухайн жилд өөрчлөгдсөн журам заавар, аудитад баримтлах чиглэл зарчмыг танилцуулж, аудитын үед хэрхэн хамтарч ажиллах талаар арга зүйн зөвлөмж өгч ажилласнаар шалгагдагч байгууллагууд аудитын үйл ажиллагааг дэмжиж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрөхөд эерэг үр дүн гарч байна.

Төрийн аудитын байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн “Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах жил” болгох зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дорнод, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрууд харилцан түншийн үнэлгээг шууд тайлагнах ажилд хамаарах гүйцэтгэлийн 3 аудит, Нотлох ажилд хамаарах 3 санхүүгийн тайлангийн аудит, нийт 6 аудитыг түншийн үнэлгээнд хамруулсан. Түншийн үнэлгээгээр цаашид анхаарч ажиллах 6 зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн Прокурорын газартай 2021 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд 2022 оны хагас жилийн байдлаар өмнөх онд шилжүүлсэн төлбөрийн актын үлдэгдлийн явцыг дүгнэж, хэлэлцсэн уулзалтыг 2022.07.05-ны өдөр зохион байгуулж ажилласан.

Харилцагч талуудын оролцооны стратеги төлөвлөгөөнд Архангай, Говьсүмбэр, Баян-Өлгий, Увс аймаг дахь Төрийн аудитын газруудтай туршлага солилцох, уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг хийх, туршлага нэвтрүүлэхээр тусгагдсан. Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас Халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөөд хийх гүйцэтгэлийн аудитыг нэгтгэн удирдаж дээрх аймгууд дахь Төрийн аудитын газруудтай теамс грүүп үүсгэж аудитын төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатуудад ярилцлага, хэлэлцүүлгийг тогтмол явуулж харилцан туршлага нэвтрүүлж ажилласан.

Орон нутгийн хэмжээнд мэргэжлийн байгууллагууд болон төрийн, төрийн бус байгууллагуудаас анхдагч болон хоёрдогч мэдээллийг байнга авч холбогдох аудитад боловсруулан ашиглаж хэвшсэн. Гүйцэтгэл, нийцлийн болон санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данснаас эхлээд цахим сайт, Сангийн яамнаас дансны хуулга зэргийг авч судалгаа, шинжилгээг авч ашигладаг.

Цахим сайтын холбоос:

- Сангийн яамны цахим сайт www.mof.gov.mn
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим сайт www.open.data.burtgel.gov.mn
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам <https://www.mofa.gov.mn/>
- Халамжийн цахим сайт www.ehalamj.mn , www.wais.hudulmur.halamj.gov.mn

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь өөрийн <https://www.facebook.com/Dornod.audit> хуудсыг ажиллуулдаг бөгөөд пейжээрээ дамжуулан тайлан мэдээг иргэдэд хүргэж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг ил тод байршуулан, иргэдээс аудитын сэдвийн саналын судалгаа авах зэргээр ашигласан.

Орон нутгийн хэвлэл, мэдээллийн Дорнод телевизтэй гэрээ байгуулан аудитын нээлт, хэлэлцүүлэг болон цаг үеийн шинжтэй бусад мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд түгээн ажиллаж байна. Мөн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар 2022 онд 154 мэдээ, мэдээлэл байршуулж 130042 иргэний хандалт авсан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3-т “иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байх” гэсэн заалтын хүрээнд аудитын сэдвийн саналыг боловсруулахдаа иргэд олон нийтээс санал авах тухай видео мэдээллийг газрын фэйсбүүк хуудсанд байршуулж иргэд олон нийтийг аудитын үйл

ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлж ажиллаж байна. Дорнод аймгийн 14 сумын төрийн болон төрийн бус байгууллагын ажиллагсад, иргэд олон нийтээс 2023 онд аудитын төлөвлөгөөнд тусгуулах аудитын сэдэв сонгох ажиллагааг 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн цахим хэлбэрээр зохион байгуулсан. Санал асуулгаар Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, ДБЭХС, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүний нөөц, Хүүхэд хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд, Прокурорын газрын хүний нөөц зэрэг 5 сэдвээр иргэд олон нийтээс санал ирүүлснээс эрэмбэлээд БОЭТ, ДБЭХС-ийн хүний нөөц, Хүүхэд хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдэд 2023 онд аудит хийх саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

6.3 Мэдээлэл сурталчилгаа



ТАБ-ын “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих” стратегийн зорилтын хүрээнд төрийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх, байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийг бодит мэдээллээр хангах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

- “Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал”, “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”, “Аймгийн халамжийн болон ЖДҮХС-гийн үйл ажиллагааны үр нөлөө”-т хийх гүйцэтгэлийн аудитын нээлт, хэлэлцүүлгийн орон нутгийн ТВ-ээр болон audit.mn сайт болон байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд түгээж ажилласан.
- ТШЗ, ТБОНӨААН, ТТЗ-дын байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, цаашид анхаарах асуудлуудын талаарх мэдээлэл болон гүйцэтгэл, нийцлийн аудитын нээлт болон үр дүнгийн хэлэлцүүлэг, орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт зэрэг мэдээллийг орон нутгийн ТВ-ээр 9 мэдээлэл түгээсэн.
- Байгууллагын албан ёсны Фэйсбүүк хуудас болон audit.mn сайтаар аудитын нээлт, явц, дүн болон цаг үеийн шинж чанартай мэдээллийн талаар нийт 154 мэдээлэл түгээж 130042 иргэний хандалт авсан байна.
- Төрийн аудитын байгууллагын audit.mn нэгдсэн сайтад “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг,” “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт,” “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг, “Нөхөн сонгуулийн зардлын гүйцэтгэл”, “Нөхөн сонгуулийн хандивын дүгнэлт”, “Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”, “ЖДХҮС-гийн үйл ажиллагааны үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудит”-уудын тайлан, Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангууд болон СТА-ын 188 аудитын тайлан нийт 197 тайланг олон нийтэд түгээж ажиллалаа.
- Мэдээллийн ил тод байдлын тайланг улирал тутамд гаргаж Үндэсний аудитын газрын Захиргаа, хууль эрх зүйн хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан шинжээч Л.Номинд хүргүүлж ажилласан.

6.4 Албан харилцаа



Газрын хэмжээнд төлөвлөгдсөн албан бичгүүд, акт, албан шаардлагын утга найруулга болон хууль зүйн үндэслэл болон тушаалын төслүүдийн боловсруулалтад хяналт тавьж, аудит болон үйл ажиллагаанд тулгамдсан асуудлуудын талаар ҮАГ-ын Аудитын газрууд болон Тамгын газраас заавар, зөвлөмж авч ажиллалаа.

Газрын 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган баталж, албан бичгийн бүртгэлийн цахим санг үүсгэн, албан бичгүүдийн шийдвэрлэлтэд бүртгэлээр хяналт тавьж хариуг хугацаанд нь өгч ажилласан.

2022 оны байдлаар цаасаар 1587 удаагийн 5692 хуудас, цахимаар 84 удаагийн 206 хуудас албан бичиг эргэлтэд орсноос явсан бичиг 579, дарга, Тэргүүлэх аудиторын тушаал А тушаал - 31, Б-тушаал – 5, төлбөрийн акт 53, албан шаардлага 292, хурлын тэмдэглэл 14, аудитын тайлан, гэрээ зэрэг бусад 134 бичиг хэвлэлтэд орж нийт 4743 хуудас хэвлэгдсэн байна.

Хүний нөөцтэй холбоотой судалгаа, мэдээ тайланг ҮАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу цаг тухай бүрд гарган заасан хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Үүнд:

- Хүний нөөцийн хөдөлгөөн, өөрчлөлтийн мэдээг сар бүрийн 20-нд ҮАГ-ын хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.
- Ажилтнуудын албан тушаал, шагнал зэрэг болон бусад мэдээллийн талаарх судалгааг ирүүлсэн чиглэлийн дагуу тухай бүр гарган ҮАГ-ын холбогдох албан тушаалтнуудад цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.
- Албан хаагчдын цалингийн тооцооллыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох дүрэм, журмын дагуу ТАЦНС-ээр гаргаж, цаг тухайд нь олгож байна.
- Газрын 2022 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ЗХЭЗГ-т хүргүүлсэн. Мөн улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ДАХШҮГ-аас баталсан маягтын дагуу гаргаж хүргүүлсэн.
- Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2018 оны А/235 дугаартай “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журам”-ын дагуу газрын 2022 оны статистик мэдээг улирал бүр гарган дарга, Тэргүүлэх аудитораар баталгаажуулж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын "А" тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гарган улирал бүрийн сүүлийн сарын 25-нд ҮАГ-ын Захиргаа, хууль, эрх зүйн газарт хүргүүлсэн. Үүнд:

- МУЕА-ын 2022 оны 1-р улиралд баталсан АНТАГ-т хамаарах 9 “А” тушаалын хэрэгжилтийг гарган 2022.3.25-нд ЗУГ-ын хуульч, шинжээч З.Төмөрбаатарын tumurbaatarz@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.
- МУЕА-ын 2022 оны эхний хагас жилд баталсан АНТАГ-т хамаарах 16 “А” тушаалын хэрэгжилтийг "Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын 11 дүгээр хавсралтын дагуу гарган ЗУГ-ын дарга, тэргүүлэх аудитор Ш.Үнэнтөгс-д 2022.06.24-ний 506 дугаар албан бичгээр, хуульч, шинжээч В.Орхоны orkhonv@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.
- МУЕА-ын 2022 оны 3-р улиралд баталсан АНТАГ-т хамаарах 21 “А” тушаалын хэрэгжилтийг "Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын 11 дүгээр хавсралтын дагуу гарган ЗУГ-ын даргын албан үүргийг түр

орлон гүйцэтгэгч Б.Билгүүнд 2022.09.24-ний өдрийн 539 дугаар албан бичгээр, хуульч шинжээч В.Орхоны orkhonv@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.

- МУЕА-ын 2022 оны 4-р улиралд баталсан АНТАГ-т хамаарах 2 “А” тушаалын хэрэгжилтийг "Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын 11 дүгээр хавсралтын дагуу гарган Захиргаа, хууль эрх зүйн газрын дарга С.Батбямбад 2022.12.12-ний өдрийн 578 дугаар албан бичгээр, шинжээч М.Номиндарийн nomindarim@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.

Мөн “Ковид-19”-ын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг долоо хоног бүрийн Пүрэв гарагт нийт 8 удаа ҮАГ-ын Тамгын газрын даргад хүргүүлж ажилласан. ДАТАГ-ын 14 хоногийн товч тайланг 3-р улирлын байдлаар нийт 13 удаа ЗУГ-ын захиргааны шинжээч Д.Эрдэнэтуяагийн erdenetuyad@audit.gov.mn хаягаар хүргүүлж ажилласан. АНТАГ-ын цахим хуралдаанаас 2022 оны 3-р улирлын байдлаар өгсөн нийт 5 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр гаргаж АНТАГ teams бүлгийн МУЕА-ын үүрэг даалгавар АНТАГ-ХШҮ нэртэй файлд байршуулсан. АНТАГ-ын цахим хуралдаанаас 2022 оны 4-р улирлын өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргаж Захиргаа, хууль эрх зүйн газрын шинжээч Д.Эрдэнэтуяагийн erdenetuyad@audit.gov.mn хаягаар 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлж ажилласан.

6.5 Өргөдөл гомдол



Газрын хэмжээнд 2022 оны байдлаар ирсэн нийт 15 хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Төрлөөр нь авч үзвэл:

- Төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн тухай – 1
- Шүүхээс тогтоосон ажиллаагүй байх үеийн цалинг олгуулах тухай – 1
- Аж ахуйн нэгжийн тендер шалгаруулалттай холбоотой – 1
- Цалингийн нэмэгдэлтэй холбоотой – 2
- Нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой – 1
- Байгууллагын албан хаагчдаас ирүүлсэн – 9 байна.

6.6 Шагнал урамшуулал



Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх хэсэгт зааснаар 11 албан хаагчдад 1-4 улирлын урамшуулалд 12,794.7 мянган төгрөгийг олгоод байна.

Монгол Улсад Төрийн хяналтын тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул, ахлах аудитор Д.Нармандах нар Төрийн дээд одон медаль “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор Б.Одхүү, М.Ухаанбилэг, С.Энхбаатар нар “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, аудитын менежер И.Сэмжидмаа, ахлах аудитор Я.Зориг нар Төрийн аудитын байгууллагын “Хүндэт жуух бичиг”-ээр тус тус шагнагдсан.

Монгол Улсад санхүү, эдийн засгийн алба үүсэн байгуулагдсаны 111 жилийн ойг тохиолдуулан дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул, аудитор Б.Одхүү нар “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, ахлах аудитор Б.Батжаргал тусгай чиг үүргийн байгууллагуудын шилдгээр шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдсан.

6.7 Нууцын хадгалалт хамгаалалт



Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг мөрдлөг болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Монгол Улсын Ерөнхий аудиторовын А/108 дугаар тушаалаар батлагдсан төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журмын дагуу нийт албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулан авсан.
- Тайлант онд нууцад хамаарах байгууллагуудын /7 цэргийн анги, Зүүн бүсийн төв Онцгой байдлын газар /санхүүгийн тайлан холбогдох материалуудыг нууц хамгаалах сэйфэнд хадгалж байна.
- ТАГ-аас 2021 онд Төрийн албаны нууц, хадгалалт хамгаалалтын чиглэлээр хийсэн ажлын тайланг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаартай албан бичгээр ЗУГ-ын дарга Ш.Үнэнтөгсд, 21 дугаартай албан бичгээр ТЕГ-ын Дорнод аймаг дахь Тагнуулын газрын дарга Б.Бямбаад хүргүүлж ажилласан.
- Үндэсний аудитын газраас зохион байгуулсан Кибер аюулгүй байдлын тухай сургалтад цахимаар хамрагдсан.

6.8 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх



- Ажилтнуудын ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулж, мэдүүлгийг meduuleg.iaac.mn сайтад бүрэн оруулж баталгаажууллаа. Авлигатай тэмцэх газрын 2020.4.23-ны өдрийн 05/5036 тоот албан бичгийн дагуу АТГ-ын даргын 2018 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан журмыг баримтлан ХАСХОМ, баталгааны маягт, бүртгэлийн дэвтэр, тайлан мэдээг архивд шилжүүлж ажиллалаа. Газрын дарга, тэргүүлэх аудитор “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргаж Монгол Улсын Ерөнхий аудиторт 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 430 дугаартай албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлсэн.
- Байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ын мэдүүлэг, нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд хянан цахим сайтад баталгаажуулсан.
- Санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит эхлэх бүрд шалгадагч этгээдэд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/93 тушаалаар батлагдсан “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам”-ыг танилцуулж, журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан /Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулсан баримт/-д гарын үсэг зуруулж хөндлөнгөөс аливаа нөлөөлөл оруулахаас сэргийлэн ажиллаж байна.
- Үүрэг хариуцлага ба ёс зүйн баталгааг дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул 2022 оны 4 сарын 18-ны өдөр гаргасан.

- Үндэсний аудитын газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг ҮАГ-ын ЗХЭЗГ-ын хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч П.Ундармаад хүргүүлсэн.

6.9 Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажлууд:



Цаг үеийн шинжтэй хийгдсэн нэмэлт ажлуудыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажилласан. (Хавсралт 4)

Төрийн хяналтын тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

1. Төрийн хяналтын тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан баримтат киноны зураг авалтад 2022 оны 5 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд ТАГ-ын ахмадууд болон албан хаагчид, харилцагч талуудыг хамруулан оролцлоо.
2. ТАБ-ын онол практикийн бага хуралд "Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын EQ чадварын үнэлгээний түвшний судалгаа" сэдэвт илтгэлээр оролцож 2 дахь шатны шалгаруулалтад амжилттай оролцлоо.
3. ТАГ-ын нийт 7 албан хаагчдыг шагналд тодорхойлж Монгол Улсад Төрийн хяналтын тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойгоор Төрийн одон медаль болон салбарын шагналуудаар шагнууллаа. Үүнд: "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар 2, "Төрийн хяналтын тэргүүний ажилтан" цол, тэмдгээр 4, Хүндэт жуух бичиг"-ээр 2, "Төрийн хяналтын 100 жилийн ойн медаль"-иар ахмад ажилтнуудыг оролцуулан нийт 11 хүн шагнагдлаа.
4. ҮАГ-аас Улаанбаатар хотод зохион байгуулсан Төрийн хяналтын тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд хамт олноороо өөрсдийн зардлаар 2022 оны 8 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд оролцлоо. Мөн Тэрэлж дэх Монгол нохой чарга амралтын газарт 2022 оны 8 дугаар сарын 27-ны өдөр "Эко" - аялал зохион байгууллаа.

Түүхт 100 жилийн ойн хүрээнд Төрийн аудитын байгууллагын хөгжлийн явц, үйл ажиллагааны ач холбогдлыг иргэд олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор "Төрийн хяналт-Аудит 100 жил" ойн арга хэмжээг орон нутагт 2022 оны 9 дүгээр сарын 05-наас 30-ны өдрүүдэд зохион байгуулахаар 5 арга хэмжээ бүхий хөтөлбөр батлан ажиллалаа. Үүнд:

1. "Төрийн хяналт-Аудит-100 жил" Аудит таны амьдралд сэдэвт танилцуулах өдөрлөгийг 2022 оны 9 дүгээр сарын 09-нд Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран амжилттай зохион байгуулж ажиллалаа.
2. "Төрийн хяналт-Аудит-100 жил" бүх нийтийн гар бөмбөгийн тэмцээнийг 2022 оны 9-р сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгуулж нийт 20 багийн 160 тамирчид оролцлоо. Тэргүүн байрыг Цагдаагийн газар, 2 дугаар байрыг Төрийн банк, 3 дугаар байрыг Дорнод их сургуулийн баг тамирчид эзэллээ.
3. "Төрийн хяналт-Аудит 100 жил" хүндэтгэлийн хурлыг 2022 оны 9 дүгээр сарын 22-нд зохион байгуулж, үе үеийн ахмад ажилтнууд, ИТХ-ын төлөөлөгчид, хамтран ажиллагч байгууллагууд оролцлоо.

4. "Төрийн хяналт-Аудит 100 жил" АСК тэмцээнийг 2022 оны 9 дүгээр 24-ний өдөр зохион байгуулж, нийт 12 баг, тамирчид оролцож, тэргүүн байрыг аймгийн Үйлдвэрчний эвлэл, дэд байрыг Онцгой байдлын газар, гутгаар байрыг Хилийн 0132-р ангиуд тус тус эзэлсэн.

5. "Төрийн хяналт-Аудит 100 жил" гурван үеийн уулзалтыг 2022 оны 9 дүгээр сарын 30-нд зохион байгуулж, уулзалтын үеэр ахмад үе, залуу үе, ХАК-ний төлөөллүүдийг хамарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

6.10 Мэдээллийн технологи



Байгууллагын сервер, сүлжээ, компьютерын аюулгүй байдлыг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Үндэсний аудитын газраас вирусны эсрэг программын шинэчлэлтийг хийхгүй байх хугацаанд мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс 1 сарын эрхтэй trial antivirus программ суулган ашигласан,
- Мөн аймгийн Харилцаа холбоо ТӨХК дээр байдаг rooter залгуур шатсан тул шинээр сольж байршуулсан,
- Байгууллагын өрөөнүүдийн свитчүүд муудаж, хуучирсан тул шинээр сольж интернетийн урсгалыг нэмэгдүүлсэн.

7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Тус газрын санхүүгийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татвар болон нийгмийн даатгалын багц хууль, холбогдох журам зааврын дагуу аккрузль сууриар илэрхийлэн "Юникус" программаар гарган ажиллаж байна. Төрийн аудитын газар нь 2022 оны 12-р сарын байдлаар Шилэн дансны цахим сайтад бүтэн жилээр оруулах 5, хагас жилээр оруулах 4, улирал бүр оруулах 3, сар бүр оруулах 33, тухай бүр оруулах 88 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан.

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллаар, сар улирлын хуваарийн дагуу зарцуулж, 436,466.8 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс 415,685.6 мянган төгрөгийг зарцуулсан нь 95.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Код	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1220	Санхүүжилтийн орлого	436,466,800.00	415,685,614.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	343,312,100.00	330,759,703.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал	48,364,000.00	40,381,907.41
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	1,380,900.00	1,380,900.00
2104	Хангамж бараа материалын зардал	12,810,500.00	12,810,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,708,300.00	5,705,900.00

2107	Томилолт, зочны зардал	8,525,000.00	8,280,703.83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,201,300.00	14,201,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	841,700.00	841,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,323,000.00	1,323,000.00

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн хугацаанд гаргаж УАГ-ын Захиргаа удирдлагын газар болон Мишээл-Од аудит ХХК-руу хүргүүлж, 2021 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж "ЗӨРЧИЛГҮЙ" санал дүгнэлт авсан. Газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 509 дугаартай албан бичгээр Мишээл-Од аудит ХХК-д хүргүүлж ажиллалаа.

Өмч хамгаалах зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөөг дарга, тэргүүлэх аудитораар 2022 оны 01 дүгээр сарын 13-нд батлуулан, 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дугаартай албан бичгээр Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Г.Эрдэнэцэцэгт хүргүүлж ажилласан. Газрын 2023 оны төсвийн төслийг боловсруулж, ЗУГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Наранцэцэгт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 488 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. “Эд хөрөнгө хүлээн авах комисс байгуулах тухай” А/12 дугаар тушаалаар тээврийн хэрэгслийг “Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 187 дугаар тогтоолын биелэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 493 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн программд 2021 оны жилийн эцсийн байдлаарх хөрөнгийг бүртгэж, улсын нэгдсэн тооллогод 2022 оны 6 дугаар сарын 22-нд хамрагдаж, Төрийн өмчийг эзэмшүүлэх 2021 оны гэрээний биелэлтийг 98 хувийн үнэлгээтэй дүгнүүлсэн. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр баталгаажуулж, ерөнхий санхүүч Г.Түвшинзаяад цахимаар хүргүүлж ажиллаж байна.

8. ДҮГНЭЛТ



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь 2022 онд ТАБ-ын хэмжээнд дэвшүүлсэн “Аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах жил” зорилтод нийцүүлэн боловсруулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 чиглэлийн хүрээнд 33 арга хэмжээнээс жилийн эцсийн байдлаар хэрэгжүүлэх 33 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлж ажиллалаа.

Батлагдсан сэдвийн хүрээнд гүйцэтгэсэн төлөвлөгөөт аудитуудыг чанар, стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхэд анхаарч, чанарын хяналтыг хэрэгжүүлэн 199 аудитыг гүйцэтгэсэн. Аудитаар нийт 28,613.2 сая төгрөгийн үр өгөөжийг шалгадагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байна. Энэ нь төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөг тутамд 65.6 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

Энэхүү ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмжийн дагуу төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагчид, ТБОНӨААТҮГ-ууд, ТЕЗ-ийн нийт 227 төсөв захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэлээ. Уг аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан аргачилсан зөвлөмжид хэрэгжүүлэхээр заагдсан нийт 6 ерөнхий чиглэлд горим, сорил хэрэгжүүлж, үр дүнг аудитын тайланд тусгаж ажиллалаа. “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл” болон “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн

тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж"-ийг хэрэгжүүлж ажилласан үр дүнгийн тайланг АНГ-ын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхланд 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 487 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

"Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл", "Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж"-ийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар батлуулан, хэрэгжүүлэх арга зүйг дэлгэрэнгүй гарган ирүүлсэн нь аудитын чанарыг сайжруулах, орон нутаг дахь аудитын газрууд нэг бодлого, нэг арга зүйгээр аудитыг гүйцэтгэж, илэрсэн асуудлыг адил түвшинд шийдвэрлэх байдалд эерэг нөлөө үзүүлж байна.


9. Шинэ санаачилга



1. ТАБ-ын 100 жилийн ойн хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулав.

Төрийн хяналт-аудит 100 жилийн ойн хүрээнд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан таниулах үе шаттай арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, аудитын тайланг олон нийтэд мэдээлэх зорилгоор "Аудит таны амьдралд" сэдэвт нээлттэй өдөрлөгийг 2022.09.08-09-ний өдрүүдэд Тусгаар тогтнолын талбай болон Найрамдал парк цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан. Нээлттэй өдөрлөгөөр 200 гаруй иргэнд ТАБ-ын үйл ажиллагааг танилцуулж, сурталчилж ажилласан.
- Бүх нийтийн спорт, эрүүл мэндийг дэмжих зорилгоор "Төрийн хяналт-аудит 100 жил" сэдэвт бүх нийтийн волейболлын тэмцээн 2022.09.10-11 өдрүүдэд Биеийн тамир, Спортын газарт зохион байгуулсан. Тэмцээнд нийт 20 багийн 160 тамирчид оролцлоо.
- Төрийн аудитын байгууллагын түүх, үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор "Төрийн хяналт-Аудит 100 жил" хүндэтгэлийн хурлыг 2022 оны 9 дүгээр сарын 22-нд зохион байгуулж, үеийн ахмад ажилтнууд, ИТХ-ын төлөөлөгчид, хамтран ажиллагч байгууллагууд оролцлоо.
- Байгууллага, иргэдийг Төрийн аудитын тухай хууль, тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор "Төрийн хяналт-Аудит 100 жил" АСК тэмцээнийг 2022 оны 9 дүгээр 24-ний өдөр зохион байгуулж, нийт 12 баг, тамирчид оролцож, тэргүүн байрыг аймгийн Үйлдвэрчний эвлэл, дэд байрыг Онцгой байдлын газар, гутгаар байрыг Хилийн 0132-р ангиуд тус тус эзэлсэн.
- Шинэ аудитуруудад аудитын ажлын туршлага, мэдлэгийг бий болгох зорилгоор "Төрийн хяналт-Аудит 100 жил" гурван үеийн уулзалтыг 2022 оны 9 дүгээр сарын 30-нд зохион байгуулж, уулзалтын үеэр ахмад үе, залуу үе, ХАК-ний төлөөллүүдийг хамарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



Төрийн аудитын байгууллагаас иргэд олон нийтэд чиглэсэн дээрх үйл ажиллагаа нь өмнө жилүүдэд хийгдэж байгаагүй ажлууд бөгөөд Төрийн аудитын байгууллагыг иргэд олон нийтэд өргөн хүрээнд далайцтай арга хэмжээгээр сурталчлан танилцуулснаараа онцлог болсон.

2. “Microsoft Teams”-программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

а. Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас нэгтгэн удирдаж гүйцэтгэсэн Аймгийн халамжийн сан болон ЖДҮХС-гийн үйл ажиллагааны үр нөлөөд хийсэн гүйцэтгэлийн аудитаар АРА, БӨА, УВА, ГСҮ аймгууд дахь Төрийн аудитын газруудтай teams программаар дамжуулан хэлэлцүүлэг уулзалтуудыг зохион байгуулж харилцан туршлага нэвтрүүлж ажилласан.



б. “Аудитын үр дүнд иргэдийн амьдрал сайжирсан байх” ТАБ-ын бодлого, чиглэлд тодорхойлсны дагуу иргэд, олон нийтийн дунд хүлээлттэй байгаа сэдвийг гаргаж ирэх зорилгоор “Googleform”-ыг ашиглаж байна. Ингэхдээ “Googleform”-д боловсруулсан санал асуулгыг байгууллагын фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан авч байгаа нь цаг хугацаа, төсөв, санхүү хэмнэж байна. Тухайлбал 2023 оны аудитын сэдвийн хүрээнд иргэдийн дунд хүлээлттэй байгаа сэдвүүдэд ДБЭХС, БОЭТ-ийн хүний нөөц, аймгаас хүүхдэд зориулж хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, Сум хөгжүүлэн сангийн асуудлууд багтаж байна.



3. Аудитын тайланг инфо-график, брендбүүк ашиглан иргэд, олон нийтэд түгээж байна.

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны Стратегийн 4.14 дэх¹ зорилгын хүрээнд тайлант онд гүйцэтгэсэн 5 гүйцэтгэлийн аудитын дүнг инфо-график хэлбэрээр бэлтгэж аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарт болон 14 суманд, фейсбүүк хуудсаар иргэд, олон нийтэд түгээж ажилласан.

Хамтын ажиллагааны хүрээнд аймгийн ИТХ-аас 4 аудитын инфо-график тус бүрийг 50 ширхэг хэвлүүлж өгсөн. Тус инфо-график тайлангаас аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарт хүргүүлж үлдэгдлийг “Аудит таны амьдралд” нээлттэй өдөрлөгөөр иргэд олон нийтэд танилцуулж ажилласан.



4. Сайн туршлагаа түгээсэн.

А. Өнгөрсөн онд аймгийн төсвийн төсөлд өгсөн санал, дүгнэлт өгөх заавар аргачлал, нэгдсэн удирдамжаар ижил түвшинд гүйцэтгэх талаар ҮАГ-ын ХБТГ-аас зохион байгуулсан онлайн хурлын үеэр дарга, тэргүүлэх аудитор илтгэл тавьж танилцуулсан. Энэхүү сайн туршлагаа түгээж ажилласны үр дүнд Монгол Улсын Ерөнхий аудитор 2022 оны А/67 дугаар тушаалаар төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлалыг журам баталж улсын хэмжээнд нэг арга зүйгээр ижил түвшинд төсвийн төсөлд аудит хийж гүйцэтгэдэг болсон.

Б. ТАБ-ын онол практикийн бага хуралд “Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын EQ чадварын үнэлгээний түвшний судалгаа” сэдэвт илтгэлээр оролцож 2 дахь шатны шалгаруулалтад амжилттай оролцсон.



5. Санхүүчдийн баярын шугаман бүжгийн тэмцээнд хоёрдугаар байр эзлэв.

Монгол улсад Төрийн сангийн тогтолцоо үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой, бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны өдрөөр төрийн болон аж ахуй нэгж байгууллагын санхүүчдийн дунд анх удаа зохион байгуулагдсан “Шугаман бүжиг”-ийн тэмцээнд байгууллагын аудитор



¹ “Харилцагч талуудын эргэх холбоо бүхий, үр дүнтэй харилцаа бий болж, иргэд аудитын үйл ажиллагаанд оролцдог болсон байна”

Б.Оюунхэрлэн, жолооч, нярав З.Шинэхүү нар оролцож хоёрдугаар байр эзлэв.

6. Прокурорын газартай байгуулсан санамж бичгийг үнэлж, дүгнэсэн.

Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд хууль зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох, тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар аймгийн Прокурорын газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд өмнөх онд шилжүүлсэн төлбөрийн актын хэрэгжилтийг үнэлж, энэ оны төлбөрийн актын үлдэгдлийг шилжүүлж ажилласан. Үүний үр дүнд Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүнд 2019 онд хийсэн аудитын хүрээнд тогтоогдсон Хэрлэн сумын гуравдугаар цэцэрлэгтэй холбоотой 2.0 сая төгрөгийн төлбөрийн актыг Прокурорын байгууллагаас мэдэгдэл хүргүүлж барагдуулсан байна.



7. Байгууллагын нэрэмжит төгөлд нэмж мод суулгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүр зохион байгуулдаг мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд 2015-2022 он хүртэл жил бүрийн хавар, намрын улиралд 20-30 мод, нийт 230 ширхэг улиас, хайлаас модны суулгацыг “Байгууллагын нэрэмжит төгөл”-д суулгаж, шинэчилсэн.

8. Түншийн үнэлгээ хийсэн.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газартай хамтран 2022 оны 10 дугаар сарын 17-оос 19-ний өдрүүдэд холбогдох аргачлалын дагуу түншийн үнэлгээ хийж, тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 585 албан бичгээр хүргүүлсэн.

10. САНАЛ



Төрийн аудитын байгууллага, түүний дотор аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын чиг үүрэг, үйл ажиллагаанд бий болгох хэрэгцээ шаардлагын талаарх санал:

- Орон нутаг дахь Төрийн аудитын газрууд нь аймгийн ИТХ-ын болон ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд төсөв мөнгөтэй холбоотой асуудал хэлэлцэх үед зөвлөх эрхтэй оролцдог байх нь Төрийн аудитын тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд үр дүн үзүүлэхээр байна. Ялангуяа төсөвт тодотгол хийх үед санал дүгнэлт хэлэх нь төсвийн тухай хууль, төрийн аудитын тухай хуулийн зорилгыг хангахад ач холбогдолтой гэж үзэж байна. Иймээс Орон нутаг дахь Төрийн аудитын газруудын өмнө хэрэгжүүлдэг байсан бодлогын чиг үүргийг сэргээх саналтай байна.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд ойрын төлөвлөгөөнд тусгуулах санал, санаачилга:

- Төрийн аудитын байгууллагын хэмжээнд төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд аудит хийх журам, заавар аргачлал, батлагдсан загвар маягттай болох саналтай байна.
- Нэгдсэн удирдамжтай аудитаар нэгдсэн тайланд тусгуулахаар хүргүүлсэн саналын шийдвэрлэлтийг эргэж мэдээлдэг байх.

- АНТАГ-ыг 5 бүсэд хуваан бүс хариуцсан газар дээрээ захиргаа хариуцсан тамгын дарга болон нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан, архив хариуцсан ажилтантай болгох талаар судалж үзэх. Мөн тэр газраа нэгдсэн удирдамжтай аудитын тайланг нэгтгэн удирддаг байх.

Төрийн аудитын газар нь дараах ажлуудыг санаачлан хийж байна. Үүнд:

- "Аудитын үр дүнд иргэдийн амьдрал сайжирсан байх" гэж ТАБ-ын бодлого чиглэлд тодорхойлсны дагуу иргэд олон нийтийн дунд хүлээлтэй байгаа сэдвийг гаргаж ирэх зорилгоор ["Googleform"](#)-ыг ашиглаж байна.
- Төрийн аудитын газраас 2022 онд хийсэн "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн", "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн", "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн", "Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг", "ЖДҮХС-ийн үйл ажиллагааны үр нөлөө", "Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн ИТХ-тай хамтран [инфо-график](#) хэлбэрээр [фэйсбүүк](#) хуудас болон [open.audit.mn](#)-аар иргэд олон нийтэд мэдээллэж ажилласан.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хавсралт 1

д/д	Сургалт
1	"Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль"-аар дарга, тэргүүлэх аудитор 2022.3.03-нд ;
2	"Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль"-аар аудитын менежер 2022.3.21-нд;
3	"Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-аар ахлах аудиторуд;
4	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан "ТАБ-аас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийг хэрхэн хэрэгжүүлж үр дүнг үнэлж тайлагнах талаар дарга, тэргүүлэх аудитор 2022.01.17-нд;
5	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг аудитын үе шат бүрд чанартай хэрэгжүүлэх арга зүйн талаар дарга, тэргүүлэх аудитор 2022.04.18-нд нийт албан хаагчдад сургалт зохион байгуулж ажилласан.
6	Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт өгөхтэй холбогдуулан "Төрийн хэмнэлтийн тухай хууль", "Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал", "Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр"-ийн талаарх сургалтыг 2022.11.18-ний өдөр санхүүгийн албаны ахлах аудитор, аудиторуд нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан.

Хавсралт 2

д/д	Сургалт
1	Санхүүгийн тайлангийн аудитын www.fas.audit.mn программаар гүйцэтгэсэн 3 болон 4 дүгээр үе шатны ажлын сургалтад нийт албан хаагчид хамрагдсан.
2	"Төрийн бодлогын үнэлгээ, төсөл хөтөлбөрт гүйцэтгэлийн аудит хийх арга зүй" сэдвээрх сургалтад нийт 7 албан хаагч хамрагдсан.
3	Тэргүүлэх аудиторудын удирдах ажилтны шуурхай хуралд 01 дүгээр сарын 10, УАГ-аас зохион байгуулсан удирдах ажилтны шуурхай хуралд 01 дүгээр сарын 12-ны өдрүүдэд оролцсон.
4	"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийх аудитын төлөвлөлтийн үе шатны ажлын талаарх хэлэлцүүлэг, хуралд нийт албан 7 хаагчид хамрагдсан.
5	ХШҮДАГ-аас зохион байгуулсан "ТАБ-ын хяналт- шинжилгээ, үнэлгээний журам, аргачлалыг танилцуулах" сэдэвт сургалтад 2022.02.17-ны өдөр дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер нар цахимаар оролцсон.
6	АГГ-аас зохион байгуулсан "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн" болон "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийх гүйцэтгэлийн аудитын арга зүйн сургалтад нийт 7 албан хаагч 2022.02.28-ны өдөр цахимаар оролцсон.
7	"Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга" мэдээллийн цагт нийт албан хаагчид 2022.03.02-нд хамрагдсан.
8	УАГ-ын Тусгай шалгалтын комиссоос зохион байгуулсан Тусгай шалгалт өгөх албан хаагчдад зориулсан сургалтад ахлах аудитор Я.Зориг, аудитор Б.Оюунхэрлэн нар 2022.03.18-ны өдөр цахимаар оролцсон.
9	УАГ-ын Мэдээллийн технологийн төвөөс зохион байгуулсан "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийн сургалтад нийт албан хаагчид 2022.03.18-нд хамрагдсан.
10	"Цахим гарын үсгийн тухай" хуулийн сургалтад нийт албан хаагчид 2022.03.18-нд хамрагдсан.

11	“Кибер аюулгүй байдлын тухай” зэрэг хуулиудын талаарх мэдээлэлд 2022.03.18-нд нийт албан хаагчид хамрагдсан.
12	Аудитор Ч.Удвалноров шинэ ажилтанд зориулсан цахим сургалтад 2022.03.28-наас эхлэн амжилттай хамрагдсан.
13	“ТХЗ-той уялдсан бодлогын хэрэгжилт болон үр дүнд суурилсан төсвийн аудитын практикийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтад нийт 6 албан хаагч 2022.3.30-нд цахимаар хамрагдсан.
14	БНХАУ-ын ТАГ, ҮАГ-аас зохион байгуулсан цахим сургалтад нийт албан хаагчид 2022.4.07-08-ны өдрүүдэд хамрагдсан.
15	АГГ-аас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг-т хийх гүйцэтгэлийн аудитын уулзалт ярилцлагад аудитын багийн гишүүд 2022.4.08-нд оролцсон.
16	АНГ, МТТ-өөс зохион байгуулсан ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитын систем fas.audit.mn-д судалгааны программын сургалтад нийт албан хаагчид 2022.04.13-нд хамрагдсан.
17	Аймгийн Орон нутгийн өмчийн газраас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого” зохион байгуулахтай холбогдсон сургалт, зөвлөгөөнд 2022.4.19-нд нягтлан бодогч, нярав нар хамрагдсан.
18	Хил хамгаалах ерөнхий газраас зохион байгуулсан 2022.4.20-ны өдрийн 9-30 цагийн сургалт аудитын нээлттэй давхацсан талаар мэдэгдэж ХБТГ-ын арга зүй хариуцсан менежер Ж.Болормаагаас Хилийн цэргийн анги-тусгай салбаруудын Санхүү бүртгэл тооцооны ажилтнуудын сургалтад “Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудит” сэдвээр арга зүйн сургалт хийх чиглэл авсан.
19	Сангийн яамнаас зохион байгуулсан төсөвт байгууллагын гүйлгээг цахимжуулах бэлтгэл ажлыг эхлүүлж, цалингийн гүйлгээг цахимаар баталгаажуулах сургалтад дарга, тэргүүлэх аудитор нягтлан бодогч нар 2022.4.27-нд хамрагдсан.
20	ХБТГ-аас зохион байгуулсан “Нийгмийн аудит” сэдэвт сургалтад 2022.5.06-нд нийт 4 албан хаагч хамрагдсан.
21	“Төрийн албан хэрэг хөтлөлт”-ийн цахим сургалтыг нийт 5 албан хаагч сонгон 2022.05.06-6.10-ныг хүртэл суралцаж төгссөн.
22	АНГ-аас 2022.05.10-ны өдөр зохион байгуулсан “Ерөнхий чиглэлийн судалгааг цахим хэлбэрт шилжүүлэх систем”-ын аудиторовн хяналтын хэсгийг танилцуулах сургалтад нийт албан хаагчид хамрагдсан.
23	ТАБ-ын сургалтын төлөвлөгөөний дагуу “Архив бичиг хэрэг”-ийн сургалтад 2022.5.16-наас нийт 4 албан хаагч хамрагдаж эхлээд байна.
24	ТАГ-ын албан хаагчдыг чадавхжуулах “Нэгдсэн сургалт-2022”-ын нээлтэд нийт албан хаагчид 2022.5.18-нд цахимаар оролцсон.
25	ТАБ-ын албан хаагчдад зориулсан “Амьдралын үнэт зүйл ба итгэл үнэмшил” сэдэвт сургалтад 2022.05.27, 06.03, 06.10-ны өдөр нийт албан хаагчид хамрагдсан.
26	“Гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтад нийт албан хаагчид 2022.06.10-нд хамрагдсан.
27	МТТ-өөс зохион байгуулсан " Системийн шинэчлэл, статистик мэдээ гаргах зааварчлага"-ын ээлжит уулзалт ярилцлагад нийт албан хаагчид 2022.06.10-нд хамрагдсан.
28	Аудиторуудыг чадавхжуулах “Нэгдсэн сургалт-2022”-д нийт албан хаагчид 2022.05.30,31-ний өдрүүдэд хамрагдсан.
29	Улаанбаатар хотын Багануур дүүрэгт ММНБИ болон ММНБИ-ийн Багануур салбарын хамтран зохион байгуулсан зүүн бүсийн мэргэшсэн нягтлан бодогчдын "Мэргэжлийн тасралтгүй хөгжил-2022" сургалтад 6 дугаар сарын 9,10-ны өдрүүдэд 4 албан хаагч оролцсон.
30	ТАБ-ын албан хаагчдад зориулсан “Хүүхдийн хүмүүжил, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга ”- сэдэвт сургалтад 2022.06.24-нд ажлын шаардлагаар 1 албан хаагч хамрагдсан.

31	ТАБ-ын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй онол практикийн бага хуралд бэлтгэсэн сэдвээр хөндлөнгийн доктор нарыг оролцуулан 2022.6.27-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан.
32	"Чанарын баталгаа ба хяналт" онлайн сургалтад 2022.6.29-нд дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер нар хамрагдсан.
33	Дарга, тэргүүлэх аудитор АНТАГ-ын цахим хуралд 2022.6.30-нд оролцсон.
34	"Өөрийгөө хөгжүүлэх, ярьж сурах I" сэдвээрх хүний хөгжлийн сургалтад 2022.09.08-нд нийт албан хаагчид;
35	"Өөрийгөө хөгжүүлэх, ярьж сурах II" сэдвээрх хүний хөгжлийн сургалтад 2022.09.16-нд албан хаагчид хамрагдсан.
36	"Төрийн аудиторын ёс зүй" сэдэвт цахим сургалтад нийт албан хаагчид 2022.09.12-ны өдрөөс эхлэн хамрагдсан.
37	"Аудитын чанарын удирдлага, үр нөлөө" сэдэвт сургалтад 2022.09.22-нд нийт албан хаагчид хамрагдсан.
38	"Удирдлагатай харилцах харилцаа, төвөгтэй харилцааг удирдах нь" сургалтад 2022.09.23-нд нийт албан хаагчид хамрагдсан.
39	"EQ буюу сэтгэл хөдлөлөө удирдах нь" сэдэвт цахим сургалтад албан хаагчид 2022.10.07-ны өдөр хамрагдсан.
40	ММНБИ-ээс Өмнөговь аймагт зохион байгуулсан "Мэргэжлийн тасралтгүй боловсрол" сургалтад 2022 оны 10-р сарын 08-10-ны өдрүүдэд аудитор Б.Одхүү хамрагдсан.
41	"Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хүлээн авах, үнэлэх, нэгтгэх модуль" цахим сургалтад албан хаагчид 2022.10.09-ны өдөр хамрагдсан.
42	"Жендерийн мэдрэмжтэй төрийн санхүүгийн удирдлага ба төрийн аудитын байгууллагуудын үүрэг оролцоо" сэдэвт цахим сургалтад албан хаагчид 2022.10.11-ны өдөр хамрагдсан.
43	"Муу зуршил, амьдралын буруу хэв маяг, учир шалтгаан" сэдэвт цахим сургалтад албан хаагчид 2022.10.14-ний өдөр хамрагдсан.
44	Gas системийн хувилбар-3, Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт оруулах модулийн тухай цахим сургалтад албан хаагчид 2022.10.17-ны өдөр хамрагдсан.
45	Төрийн албаны зөвлөлөөс 2022.10.20-нд цахим хэлбэрээр зохион байгуулсан 7:4:10 хөгжлийн сургалтад дарга, тэргүүлэх аудитор хамрагдсан.
46	"Амьдралын бусад талбараа хөгжүүлэх" сэдэвт цахим сургалтад албан хаагчид 2022.10.21-ний өдөр хамрагдсан.
47	"Мэдээлэл ба Кибер аюулгүй байдал" сэдэвт цахим сургалтад албан хаагчид 2022.10.27-ны өдөр хамрагдсан.
48	ОНХС-гийн тайланг Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэх цахим хуралд дарга, тэргүүлэх аудитор болон аудит гүйцэтгэсэн багийн гишүүд 2022.11.01-ний өдөр оролцсон.
49	"Тархины харвалт, түүнээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт цахим сургалтад албан хаагчид 2022.11.02-ний өдөр хамрагдсан.
50	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан, "Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих" зорилготой цахим сургалтад албан хаагчид 2022.11.03-ны өдөр хамрагдсан.
51	"Харилцааны сэтгэл зүй-II" сэдэвт цахим сургалтад албан хаагчид 2022.11.04-ны өдөр хамрагдсан.
52	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад дарга, тэргүүлэх аудитор 2022.11.07-ны өдөр оролцсон.
53	"Цагийн менежмент" сургалтад 2022.11.25-нд нийт албан хаагчид хамрагдсан.
54	"Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо" сургалтад дарга, Тэргүүлэх аудитор, аудитын менежер, 2 ахлах аудитор, 3 аудитор хамрагдаж, 2022.11.30-нд эцсийн сорил өгч, бүгд тэнцсэн.
55	"Өөрчлөлтийн менежмент II" сэдэвт сургалтад 2022.12.02-нд нийт албан хаагчид хамрагдсан.

56	"Өгөгдлийн шинжилгээ" сэдэвт сургалтад ахлах аудитор Б.Батжаргал 2022.12.02, 2022.12.05, 2022.12.09-ний өдрүүдэд хамрагдсан.
----	--

Хавсралт 3

д/д	Сургалт
1	Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулдаг салбар зөвлөлийн гишүүд, төрийн албан хаагчийн онлайн сургалтад дарга, тэргүүлэх аудитор 12 удаа хамрагдсан.
2	Улаанбаатар хотын Багануур дүүрэгт ММНБИ болон ММНБИ-ийн Багануур салбарын хамтран зохион байгуулсан зүүн бүсийн мэргэшсэн нягтлан бодогчдын "Мэргэжлийн тасралтгүй хөгжил-2022" сургалтад 6 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд 4 албан хаагч оролцсон.
3	Жолооч, нярав З.Шинэхүү Дорнод аймгийн Дорнод их сургуульд бизнесийн удирдлагын магистраар суралцаж төгссөн.
4	Аудитор М.Ухаанбилэг Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуульд эрх зүйч мэргэжлээр суралцаж байна.
5	Аудитын менежер И.Сэмжидмаа Оюун ухааны академиас зохион байгуулсан "Ой тогтоолт ба сэтгэхүй хөгжүүлэх" сургалтад 2022 оны 5 дугаар сарын 14-15-нд хамрагдсан.
6	Аудитор Б.Одхүү МУИС-ийн Дорнод аймаг дахь сургуульд Бизнесийн ухааны магистраар суралцаж байна.
7	Аудитор, нягтлан бодогч Б.Оюунхэрлэн Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сорил шалгалтын сургалтад 2022.10.20-2022.11.10-ны өдрүүдэд суралцсан.

Хавсралт 4

д/д	Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажил
1	Төрийн аудитын дээд байгууллага ҮАГ-аас ирүүлсэн нийт 24 цаг үеийн шинжтэй чиглэл, тайлан, мэдээ, биелэлтүүдийг холбогдох газар, хэлтэс, албан тушаалтнуудад заасан хугацаанд нь гаргаж хүргүүллээ.
2	ТАГ-ын 14 хоногийн товч тайланг эхний хагас жилийн байдлаар нийт 10 удаа ЗУГ-ын захиргааны шинжээч Д.Эрдэнэтуяагийн erdenetuyad@audit.gov.mn хаягаар хүргүүлж ажилласан.
3	Шууд тайлагнах аудитын явцын мэдээг 14 хоног тутам эхний хагас жилийн байдлаар нийт 12 удаа data.audit.mn цахим бүртгэлийн системд байршуулсан.
4	АНТАГ-ын цахим хуралдаанаас 2022 оны 2-р улирлын байдлаар өгсөн нийт 5 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр гаргаж АНТАГ teams бүлгийн Монгол Улсын Ерөнхий аудиторовн үүрэг даалгавар АНТАГ-ХШҮ нэртэй файлд байршуулсан.
5	Удирдлагын шуурхай хуралдаанаас 2022 оны 2 дугаар улирлын байдлаар өгсөн нийт 3 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр гаргаж АНТАГ teams бүлгийн Монгол Улсын Ерөнхий аудиторовн үүрэг даалгавар АНТАГ-ХШҮ нэртэй файлд байршуулсан.
6	Дарга, тэргүүлэх аудитор Хил хамгаалах ерөнхий газрын хилийн ангиудын зүүн бүсийн сургалтад санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийтлэг алдаа зөрчлийг танилцуулж, цаашид анхаарах асуудлаар арга зүйн сургалт өгөв.
7	Санхүүгийн тайлангийн аудитаар бие даасан дүгнэлт гаргасан нийт 189 төсвийн захирагч тус бүрд аудитын дүгнэлт бүхий тайлангийн хамт аудитын хураангуй тайланг бэлтгэн, хүргүүлж ажилласан.

8	Гүйцэтгэлийн аудитаар 2022 оны эхний хагас жилд гүйцэтгэж дууссан "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн", "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн", "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" тус бүр хураангуй тайланг бэлтгэн ажилласан.
9	Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд 2021 онд өгсөн төлбөрийн акт, албан шаардлага болон Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлт, шүүхээр хянагдсан хэрэг маргааны судалгааг 2021 оны жилийн эцсийн байдлаар хавсралт маягтын дагуу гаргаж, ЗУГ-ын дарга, тэргүүлэх аудитор Ш.Үнэнтөгсд 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.
10	ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу "Ашдын нөхөр" ХХК-ний "Дорнод" телевизтэй 18 ажлын 240 минутын үйлчилгээ авахаар 1.8 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээг байгуулсан.
11	Дорнод аймгийн ИТХ-аас баталсан орон нутгийн 2022 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1, 33.2.7-д заасан бүрдлийн дагуу гаргаж 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаартай албан бичгээр АНГ-ын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхланд болон pdf болон excel файлаар tt@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.
12	Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016-2020 оны санхүүгийн тайланг баталгаажуулсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийсэн жагсаалтыг гаргаж Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүхд 2022.01.25-ны өдрийн 13 дугаартай албан бичгээр, мөн bulganb@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.
13	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүн"-д хийх аудитын төлөвлөлтийн үе шатны ажлын хүрээнд аудитын хамрах хүрээ, асуудлын шинжилгээнд оруулах саналыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүхд 2022.01.31-нд 19 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.
14	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/221 дүгээр тушаалаар батлагдсан "Аудитын чанарын хяналтын журам"-ын шинэчлэлтэй холбоотой нийт 10 саналыг Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бундхоролд 2022.4.11-ний 428 дугаартай албан бичгээр мөн aniru@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.
15	БШУ-ны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны аудитын тайланг pdf файлаар аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн нэгтгэлийн хамт 2022.4.13-нд АХГ-ын аудитор Ж.Энхтуяад enkhtutaj@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.
16	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан ТАБ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалын 28 дугаар хавсралтын №15 маягтын дагуу тоон мэдээллийг "АНТАГ" TEAMS группд 2022.4.15-нд байршуулсан.
17	ЗЕХ-ийн 103-р зүйлийн 103.1, 103.2, 103.3 дугаар заалтуудтай холбоотой судалгааг шалгадагч байгууллагуудаас авч нэгтгэн 2022.4.05-нд Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүхд 407 дугаартай албан бичгээр мөн ЗУГ-ын хуульч шинжээч В.Орхоны orkhonb@audit.gov.mn хаягаар хүргүүлсэн.
18	Төрийн аудитын нэрийн өмнөөс төрийн болон өмчит нийт 80 байгууллагад "Хаан консалтинг аудит" ХХК-аар санхүүгийн тайлангийн аудитыг холбогдох хууль, стандарт, нэгдсэн бодлого журмын дагуу гүйцэтгүүлсэн. "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хүрээнд санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэсэн эсэхэд "Аудитын чанарын хяналтын журам"-ын дагуу аудитын үе шат бүрд чанарын хяналтуудыг нийт 80 төсвийн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хэрэгжүүллээ. Мөн fas.audit.mn программаар давхар гүйцэтгүүлж, үе шат бүрд чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

19	МУЕА-ын 2020 оны А/81 тушаалаар баталсан "Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам"-ын маягт-2, 3, 4, 5-ын дагуу Хаан консалтинг аудит ХХК-ны гүйцэтгэсэн 80 байгууллагын аудитын үе шат бүрд үнэлгээ өгч, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 85.3 хувьтай дүгнэж "Хаан консалтинг аудит" ХХК-д хүргүүлэн ажилласан.
20	"Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" МУЕА-ын 2022 оны 10 дүгээр сарын 06-ны өдрийн А/75 дугаар тушаалаар тус аймагт 2023 онд санхүүгийн тайлангийн аудитад 228 байгууллага хамрагдахаар батлагдсан. Аудиторуудын 2023 онд хийх СТА-ын хуваарийг fas.audit.mn системд оруулан хяналт тавин ажиллаж байна.
21	ТАБ-ын албан хаагчдын судалгааг 2022.5.18-нд ЗУГ-ын хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч Г.Лхагвадуламын эйблэ хаягаар хүргүүлсэн.
22	Аудиторуудын ажлын ачааллын судалгааг ХШҮДАГ-ын аудитын менежер С.Нямсүрэнгийн nyamsurens@audit.gov.mn хаягаар 2022.6.13-нд хүргүүлсэн.
23	ТАБ-ын үйл ажиллагааны тогтолцоог сайжруулах, асуудал шийдвэрлэх арга замыг эрэлхийлж судлах эрсдэлийн судалгааг ХШҮДАГ-ын аудитын менежер С.Нямсүрэнд эйблээр 2022.6.14-нд хүргүүлсэн.
24	ТАГ-ын албан хаагчдын 2021 оны цагийн бүртгэлийг эйблэ программаас татаж ХШҮДАГ-ын аудитын менежер С.Нямсүрэнд 2022.6.14-нд эйблээр хүргүүлсэн.
25	Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2022 оны 6 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд ҮАГ-ын ХШҮДАГ-аас ТАГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийлээ.
26	Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны эхний хагас жилийн АНТАГ-т хамаарах 16 тушаалын хэрэгжилтийг гаргаж, ЗУГ-ын дарга, тэргүүлэх аудитор Ш.Үнэнтөгсд 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 506 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.
27	Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/104 дүгээр тушаалаар баталсан "Аудитын сэдэв батлах журам"-ын дагуу 2023 онд шалгагдагч байгууллагуудын жагсаалт, аудит хийх хэлбэрийг ХБТГ-ын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхоролд 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 495 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.
28	МУЕА-аас өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр ажилтан албан хаагчдад танилцуулж хэрэгжүүлэн ажилласны дүнд 2022 оны жилийн эцсийн байдлаар МУЕА-ын гаргасан 20 "А" тушаалын хэрэгжилтийг гарган ажиллалаа. Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнөөр өгсөн 10, удирдлагын шуурхай хуралдаанаар өгсөн 3, АНТАГ-ын цахим хуралдаанаар өгсөн 8 үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн биелэлтийг гарган ҮАГ-т хүргүүлсэн.
29	ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу байнга хэрэгжүүлэх гүйцэтгэл нийцлийн аудитын хэрэгжилт явцын мэдээг 14 хоног тутам, ТАГ-ын хураангуй тайланг 14 хоног тутам, ТАГ-ын хүний нөөцийн хөдөлгөөний мэдээг сар бүрийн 20-нд хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.
30	ҮАГ-ын чанарын баталгаажуулалтын газраас "Аймаг дахь Төрийн аудитын газрын чанарын хяналтын тогтолцооны болон аудитын түвшинд чанарын баталгаажуулалт хийх удирдамж"-ийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 15-аас 21-ний хооронд хийсэн чанарын баталгаажуулалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-нд цахим хэлбэрээр хүргүүлж ажилласан.
31	ХШҮДАГ-аас газрын зарим үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг ДАХШҮГ-т 2022 оны 11 дүгээр сарын 01-нд цахим хэлбэрээр хүргүүлээ.
32	ТАГ-ын 2022 оны гүйцэтгэлийн тайланг гарган 12 дугаар сарын 16-ны өдрийн 579 дугаар албан бичгээр ҮАГ-ын Тамгын газрын дарга С.Цэрэнбаярт хүргүүлж ажиллалаа.



33	Монгол Улсад Төрийн хяналтын тогтолцоо үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүрээнд хөтөлбөрийн дагуу “Аудит бидний амьдралд” нээлттэй өдөрлөгийг 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр, “ТАБ-100” гар бөмбөгийн тэмжээнийг 2022 оны 09 дүгээр сарын 10-наас 11-ны өдрүүдэд, “ТАБ-100” хүндэтгэлийн хурлыг 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр, “Төрийн хяналт-Аудит100” АСК тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр, “Төрийн хяналт-Аудит 100” гурван үеийн уулзалтыг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулж ажилласан.
34	2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд тусгуулах аудитын сэдвийн саналыг аймгийн иргэд, олон нийтээс цахимаар ирүүлсэн болон өмнөх онуудад хийгдсэн аудитуудын дүнг харгалзан эрсдэлтэй гэж үзсэн 4 сэдвийг аудитын төлөвлөгөөнд тусгуулахаар ҮАГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 515 дугаар албан бичгээр хүргүүлсэн.